

## МОНГОЛ ХЭЛНИЙ ТҮҮХ БА ТОГТОЛЦОО <sup>1</sup>

Шигэо Озава (япон хэлнээс орчуулсан Л. Энхсайхан \*)

Манай улсад монгол хэл гэвэл монгол бичгийн хэл гэсэн утгаар хэрэглэх тохиолдол нийтлэг боловч нөгөө талаар халх монгол хэлийг заах нь ч бас байдаг. Монгол хэл нь дээрхтэй холбоогүй, зөвхөн монгол нутаг дэвсгэрт хэрэглэж ирсэн, одоо хэрэглэж буй хэлийг ерөнхийд нь илэрхийлж буй утга юм.

Гэвч шинжлэх ухааны үүднээс нарийвчлан нотлох шаардлагатай үед иймэрхүү нэр томъёоны тодорхой бус байдлаас зайлсхийхийн тулд, юуны өмнө энэхүү нэр томъёоны талаар товчхон дурдах нь зүйтэй юм.

Нэгдүгээрт, монгол хэл (蒙古語) гэдэг үгээр монголчуудын өнгөрснөөс одоо хүртэл хэрэглэсээр ирсэн монгол язгуурын хэлийг ерөнхийд нь заамаар байна. Ялангуяа монгол язгуурын хэмээн бичиж байгаа нь монголчууд нэгэнт өөрийн хэлийг хэрэглэлгүй бусад үндэстний хэл тухайлбал хятад, орос, перс язгуурын хэлийг хэрэглэж байсан үе байдаг учраас энэ нь хамгийн өргөн утгатай нэр томъёо болох юм.

Хоёрдугаарт, Одоогийн БНМАУ-ын ихэнх нутаг дэвсгэрт хэрэглэж буй хэлийг Халх монгол хэл (*Khalkha-Mongolische*) монгол хэл гэж нэрлэе. Миний бие дайны дараа японд ирж байсан олон монголчуудтай уулзаж, хөөрөлдөх завшаан олдож байсан бөгөөд тэд өөрийн улсыг Монгол хэмээн нэрлэн, өөрсдийн ярих хэлийг монгол хэл гэж хэлж байлаа. Энэ нь бид гадаад хүмүүст бидний ярих хэл япон хэл гэдэгтэй яг адил юм. Иймээс одоогийн БНМАУ-д өргөн хэрэглэх халх язгуурын монгол хэлийг товчхондоо монгол хэл гэж нэрлэе.

<sup>1)</sup> Хаттори Широкийн эмхэтгэсэн “Хэлний тогтолцооны түүх” номын 241-278-р хуудас / 服部四郎編、『言語の系統の歴史』、岩波書店、1971.

\* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Гадаад хэлний тэнхим

Монгол хэлээс гадна олон газарт хэрэглэж буй монгол язгуурын хэлний тухайд өмнө нь сурч байсанчлан тийм тийм аялгуу жишээ нь: цахар аялгуу, буриад аялгуу, дагуур аялгуу зэрэг нэр томьёог хэрэглэн цахар хэл, буриад хэл, дагуур хэл гэсэн нэр томьёо хэрэглэхгүй. Мөн нэг аялгууг дотор нь нарийн хуваах тохиолдолд тийм тийм аялгуу гэж нэрлэн тусгай нэр томьёо хэрэглэлгүй жишээ нь буриад аялгууны алар аялгуу гэж нэрлэхтэй адил юм. Буриад аялгууны алар доод аялгуу гэдэгчлэн доод аялгуу гэдэг нэр томьёог хэрэглэж болно гэж бодогдож байгаа ч энэхүү өгүүлэлд тийм ч холбоотой гэж бодогдохгүй байна.

*Гуравдугаарт*, Эдүгээ уйгур язгуурын монгол үсгээр буулгасан үсгийн хэлийг монгол бичгийн хэл (蒙古文語) гэж нэрлэн жигдрүүлж, монгол хэлний бичгийн хэл (蒙古語文語), бичгийн монгол хэл (文字蒙古語) гэсэн нэр томьёог хэрэглэхгүй. Мөн 1941 оны бичиг үсгийн өөрчлөлтийн дараа монгол хэлэнд (モンゴル語) суурилсан кирилл үсгийн бичгийн хэлийг монгол бичгийн хэл (モンゴル文語) гэж нэрлэн хоёр төрлийн үсгийн хэлийг ялгаж байна. Энэхүү (モンゴル文語) монгол бичгийн хэл нь эртний (蒙古語文語) сонгодог бичгийн хэлээс ялгаатай, орчин цагийн ярианы хэлний төлөөлөх хэл болох монгол хэлд суурилсан өөрөөр хэлбэл ярианы болон бичгийн хэлийг нэгтгэсэн бичгийн хэл юм.

Монгол бичгийн хэлийг (蒙古文語) одоо хэрэглэж байгаа хэлнээс ялгаатай эртний бичгийн хэл гэж үзвэл адилхан бичгийн хэлний хувьд чанарын ялгаа байгааг анхаарах хэрэгтэй юм.

Энэхүү өгүүлэлд нэр томьёоны хувьд ялгаатай зүйл байгааг тэмдэглэсэн бөгөөд энэхүү хэлийг тухайн цаг үеийнх нь үүднээс нэрлэх тохиолдолд эртний монгол хэл (古代蒙古語), дундад үеийн монгол хэл (中世蒙古語) гэж нэрлэхээр шийдлээ.

## **1. Монгол хэлний түүх**

1.1. Аливаа хэлний түүхийг өгүүлэх нь ихэнхдээ хүндрэлтэй ажлын нэг бөгөөд монгол язгуурын хэлний түүхийг өгүүлэхэд ч мөн адил юм. Монгол хэл нь цаг хугацаа, орон зайн хувьд ялгаатай шинж бүхий бүхий л монгол хэлийг багтаасан ойлголт учраас дээр тодорхойлсноор монгол хэлний түүх гээд авч үзвэл хангалттай бус гэж шүүмжлүүлэхээс зайлсхийж чадахгүй нь мэдээж боловч ямар нэгэн хэмжээгээр ерөнхий дүр зургийг гаргаж чадах болов уу гэж бодном.

Монгол хэлний судалгааг 13-р зууны хэлээс эхлэх нь зүйтэй юм. 13-р зуунаас 16-р зууны сүүлч эсвэл 17-р зууны эхэн хүртэлх монгол хэлийг дундад үеийн монгол хэл гэж нэрлэх бөгөөд энэхүү дундад үеийн монгол хэлний хэрэглэгдэхүүнд хэд хэдэн онцлог, ялгаа бүхий дурсгалт бичгүүд байх агаад судлах тааламжтай боломжийг олгож байна.

1. Уйгар монгол үсгээр тэмдэглэсэн сонгодог бичгийн өмнөх үеийн (*the pre-classical written Mongolian*) дурсгал

2. Ханз үсгийн дуудлагаар тэр үеийн монгол хэлээр тэмдэглэсэн монгол хэлний дурсгал

3. Хувилай хааны 1269 онд зохиосон Пагва үсэг буюу дөрвөлжин үсгийн монгол хэлний дурсгал

4. Араб үсгээр тэр үеийн монгол хэлээр буулгасан араб үсгийн монгол хэлний дурсгал

Дээр дурдсан дөрвөн зүйлийн дурсгал байна. Түүнээс өөр хэрэглэгдэхүүн байвч дэндүү ховордсон учраас энд дурдахаа хойшлуулья.

Энэхүү 4 төрлийн дурсгалын судалгаагаар 13-р зуунаас 15-р зууны эхэн үе хүртэлх монгол хэлний тоймыг бараг гаргаж чадах учраас монгол хэлний түүхийг нотлох дурсгал нь энэхүү дундад үеийн монгол хэлний үе шатаас эхлэнэ гэж хэлж болно.

1.2. 13-р зуунаас өмнөх монгол язгуурын хэлний тухайд одоогийн байдлаар бидэнд хэмжээ болон чанарын хувьд хангалттай бичгийн дурсгалын хэрэглэгдэхүүн байхгүй байна. Тиймээс энэ цаг үеийн монгол хэлийг эртний монгол хэл гэж нэрлэвэл эртний монгол хэлд холбогдох тэмдэглэл, түүний ихэнхийг таамаглахаас хэтрэхгүй байвч 13-р зуунаас өмнөх монгол язгуурын хэлний хэрэглэгдэхүүн байхгүй гэвэл бас тийм биш юм. 10-р зууны эхэн үеэс 12-р зууны эхэн хүртэлх Ляогийн хаант улсын Кидан үндэстний хэл нь 10-р зууны үеийн монгол язгуурын хэл гэж үзэх боломжтой юм. Энэхүү кидан үндэстний хэл нь монгол язгуурын хэл байсан уу үгүй юу гэдгийн тухайд эртнээс маргаантай байсан бөгөөд миний бие Нацүки Асада профессорын бичсэн Ханз үсгийн кидан хэлний хэрэглэгдэхүүнийг нягталж үзсэний дүнд кидан үндэстний хэл нь дундад үеийн монгол хэлнээс нэг үеийн өмнөх монгол хэл байсан гэж үзэж болох болов уу гэж бодож байна.

**Кидан хэл.** Кидан үндэстний, өөрийн хэл болох кидан бичгийг амжилттай тайлж уншаагүй өнөө үед бид кидан хэлний ерөнхий хэв шинжийг олж мэдэж чадаагүй боловч, кидан үндэстний хэлийг ямар бүлэгт хамаарах хэл байсан бэ гэдгийг тодруулах баримтгүй гэж болохгүй. Ийм баримт нь доктор Куракичи Ширатори, проф. Нацүки Асада<sup>1</sup>, проф. Шичиро Мураяма<sup>2</sup> нарын бичсэн ханз үсгийн дуудлагатай ойролцоо тэмдэглэсэн кидан хэлний хэдэн үг юм. Энэ ханз үсгийн авианы орчуулга кидан хэлний үгийн санг нягталж үзэхэд түүний ихэнх нь монгол хэлээр тайлж уншиж чадсан үгнүүд байлаа. Түүний хоёр гурваас дор жишээ татъя..

<sup>1</sup> 長田夏樹「契丹文字解読の可能性」神戸外大叢第2巻第4号、昭和26年.

<sup>2</sup> 村山七郎「契丹文字解読の方法」言語研究17、8号、昭和26年.

① [史]三月三日— 国語謂是日為陶里樺、陶里兔也、樺射也。〔解 115〕陶里樺—上巳日射兔乏節名。〔契〕上巳—北呼此節為淘裏化、漢人訳云、淘裏是兔，化是射。〔欽 X〕*taola garbuga* 射兔乏謂

② [史]五月重五日—国語謂是日討賽咿呢，討五，賽咿呢月也、〔解 116〕討 賽咿呢 —重午日。〔契〕端午—北呼此節為耐賽離。〔欽 X〕*tob ineggi* 滿州語托卜端也，伊能伊日也，

② [史]奪里本幹魯朶穆宗置，是為延昌宮，討平日奪里本。〔解 139〕奪里本—討平也〔欽 II〕*dayilaha* 滿州語已討乏。

дээрх жишээг Асада профессорын өмнө дурдсан өгүүллийн ханз кидан хэлний хэрэглэгдэхүүнээс ашигласан бөгөөд дээр дурдсан хэрэглэгдэхүүний [史] нь Ляогийн түүх (遼史)「四部備要」本, [解] нь Ляогийн түүхийн дэвтэр 116 (遼史卷 116, 国語解), [契] нь 契丹国志(文庫本) гэсэн үгийн товчлол бөгөөд Асада профессорын дээр дурдсан өгүүллээс 「陶里兔也，樺射也；淘裏是兔，化是射」, 「討五，賽咿呢月也」、 「討平日奪里本; 奪里本—討平也」 зэрэг ханзны авианы орчуулга бүхий Кидан хэлний үг монгол язгуурын хэлний үгтэй ойролцоо хэлбэртэй байх боломжтой юм.

Хамгийн эхэнд дурдсан 「陶里兔也，淘裏是兔」 ны 陶里，淘裏 нь хоёулаа *tau-li* гэсэн дуудлагатай гэж бодож байгаа бөгөөд энэ нь монгол хэлний *taulai* (兔)-тай ойролцоо юм. Монгол хэлээр (兔) *туулай* гэсэн утгатай үг

(mo.)<sup>1</sup> *taulai*, (秘.)<sup>2</sup> 討来 *taulai* (pa.)<sup>3</sup> *taulai* (華·甲.)<sup>4</sup> 討来 *taulai*

(mon.)<sup>5</sup> *туулай* (kalm.)<sup>6</sup> *tül* (bur.)<sup>7</sup> *туулай* (ord.)<sup>8</sup> *tülā* (cha.)<sup>9</sup> *tülā* (dung.)<sup>10</sup> *таулэ*

(mong.)<sup>11</sup> *tūli*

үгтэй адил бөгөөд бүгд бичгийн хэлний *taulai* гэсэн үг юм. 陶里，淘裏-ийн *tauli* -

1) (mo.) монгол хэл

2) (秘) нууц товчооны монгол хэл

3) (pa.) дөрвөлжин үсгийн монгол хэл

4) (華·甲) 華夷訳語甲種本

5) (mon.) орчин цагийн монгол хэл

6) (kalm) халимаг аялгуу

7) (bur.) буриад аялгуу

8) (ord.) ордос аялгуу

9) (cha.) цахар аялгуу

10) (dung.) дуншан аялгуу

11) (mong.) монгол аялгуу

(mo.) F.D. Lessing, *Mongolian-english dictionary*, Berkeley and Los angeles, 1960. (秘)は四部叢刊本による. (pa.) N.Poppe, J.R.Krueger, *The Mongolian Monuments in Hp' ags-Pa Script*, Wiesbaden, 1957 (華·甲) 華夷訳語上・下. (mon.) Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966. (kalm.) G.J. Ramstedt, *Kalmückisches Wörterbuch*, Helsinki, 1935. (bur.) К.М. Чермисов, *Бурят-монгольско-русский словарь*, Москва, 1951. (ord.) A. Mostaert, *Dictionnaire ordos*, Peking, 1941. (cha.) 東京外国語大学講師スンヂク・スブグドルヂ. (dung) Б.Х. Тодаева, *Дунсянский язык*, Москва, 1961. (mong.) A. Smedt, A. Mostaert, *Dictionnaire monguor-français*, Pei-ping, 1933.

тай яг адил хэлбэртэй биш боловч *taulai*-тай ойролцоо гэдгийг үгүйсгэх аргагүй юм. Мөн үгийн тухайд профессор Мураяма, Асада нар дурдсан байдаг.

「樺射也;化是射」-ийн 樺, 化 хоёулаа *xua*-аар илрэх боловч монгол хэлээр *харвах* гэсэн үг нь

(mo.) *qarbu*- (秘)<sup>中</sup>合兒鑊 *qarbu*- (華・甲)<sup>中</sup>合兒卜 *qarbu*- (mon.) *xarwa* (kalm.) *xarwa*<sup>a</sup>- (bur.) *xarba*- (ord.) *xarwu*- (cha.) *xarwa*- (dag.)<sup>1</sup> *qarbā*- (mong.) *xarmu*-

тай адил *qarbu*-, *xarwa*- нь нийтлэг байх агаад кидан хэлний 樺, 化-аас дуудлагын хувьд нэлээд ялгаатай тул энэ хоёр үгийг харьцуулан тогтоох боломжгүй юм. Гэвч *qarbu*- нь 射る) харвах гэсэн утгатай үгийн хувьд нөгөө талаар *qa*-, *xa*- гэх үг ч эртнээс монгол хэлэнд байсан биш үү гэж бодогдном. Тэгвэл (R.K.W.)<sup>2</sup>-д

*xarw<sup>o</sup> xa (xarw xv) mit dem bogen schiessen; geöohnl хахв*

гэсэн зүйл тохиолдохоос гадна Нууц товчооны монгол хэлэнд ч дараах хэлбэрүүд байна.

〔秘〕五 34 三§163. 秣舌驪訥安 <sup>中</sup>忽牙 <sup>中</sup>合墨峇 周

馬 目的 腿 被射着

*morin-uun quya qaqađu*..... 自分の馬の腿を射られて.....

энэхүү *qaqađu*-ийн хажуугийн хадмал орчуулга 被射着-аас мэдэж болох ба харвахын үйлдэгдэх хэвийн нөхцөл *-qda*- г авбал *qa*- нь мэдээж *харвах* гэсэн үгийн үндэс болох юм. Энэхүү *qa*-, *xa*- г харвах (射る) гэсэн талаас авч үзвэл 樺, 化-тай нэлээд ойртож очих *qarbu*- тай харьцуулан тогтоохоос илүү хэцүү биш юм.

② -рт дурдсан 討五, 賽咿呢-ийн 「討五」 нь 討= *tau* болох учраас доорх монгол хэлний олон хэлбэрүүдтэй ойролцоо юм.

(mo.) *tabu(n)* (秘)塔不 *tabu (pa) tabu(n)* (華・甲.) 塔奔 *tabun*

(mon.) *тав(ан)* (kalm.) *tawŋ* (bur.) *таба(н)* (ord.) *tawu* (cha.) *taw*

(dag.) *таав*<sup>3</sup> (bao.)<sup>4</sup> *тавон* (dung.) *тавуан* (mong) *t'awen*

мөн 「賽咿呢月地」-ийн 「賽咿呢」 нь *saiir~ sajir* -тай ойролцоо дуудагдаж байгаа бөгөөд монгол хэлний сар (月) утгатай үг нь

(mo.) *sara (n)* (秘) 撒<sup>舌</sup>刺 *sara (pa) zara* (華・甲.) 撒<sup>舌</sup>刺 *sara*

(mon.) *сар(ан)* (kalm.) *sar<sup>o</sup>* (bur.) *hara* (ord.) *sara* (cha.) *sar*

(dag) *сар* (bao) *сарэ* (*тж .сэра*) (dung.) *сара* (mong) *sara*

гэж байдаг учраас *sajir; sara* нь дээрх 討 *tau; tabu~тав (taw)*-тай харьцуулахад ойролцоо

<sup>1</sup>) (dag) дагуур аялгуу

<sup>2</sup>) G.J. Ramstedt, *Kalmückisches Wörterbuch*, Helsinki, 1935

<sup>3</sup>) (dag.) дагуур аялгууны товчлол, Н.Н. Поппе, *Дагурское наречие*, Ленинград 1930.

<sup>4</sup>) (bao) – баонь аялгууны товчлол, Б.Х. Тодаева, *Баонский язык*, Москва, 1964

зүйл байхгүй гэж хэлж болох бөгөөд ханз үсгээр гадаад үгийг тэмдэглэсэн энэ төрлийн дурсгалуудын зөв эсэхийг бодоод үзэхэд энэ хэмжээний ялгаа, зөрүү хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна гэж хэлж болно.

③-ын 奪里本 нь *duoliben* өөрөөр хэлбэл үүнтэй ойролцоо дуудлагатай гэж үзэж болно. 討平-ийг илэрхийлэх үг монгол хэлэнд дээрх *duoli—ben* нь өнгөрсөн цагийн дагавар гэж бодож байгаа бөгөөд *-n* нь олон тооны хэлбэр биш үү? хэмээн харьцангуй ойролцоо гэж харагдах үгэнд Мураяма<sup>1</sup> профессорын нууц товчоонд [秘] -нд 倒兀里 *dau 'uli-* гэдэг үг тохиолдох бөгөөд үүнээс гадна бичгийн хэлний *tuγuli-tuuli* гэдэг үг ч бас байдаг. Энэ үг 1966 онд Улаанбаатарт хэвлэгдэн гарсан Монгол хэлний товч тайлбар тольд:<sup>2</sup>

*туулих дайн байлдааны газар уулгалан олз авах* (戦場で先駆けして、戦利品をとる) гэсэн байх бөгөөд бичгийн хэлний хэлбэр нь *tuuliqu* юм. (К.М.Р.Ф.С)<sup>3</sup> -д *tuuli-*, *tuγuli-* гэсэн 2 хэлбэр тэмдэглэгдсэн байх агаад, миний хувьд *tuγuli-* нь зохиосон бичгийн хэлбэр бөгөөд угтаа *tuuli-*, (*tūli-*) гэх хэлбэр байсан биш үү гэж бодож байна.<sup>4</sup> Энэхүү *tuuli-* нь кидан хэлний *duoli-* тай нэлээд ойролцоо боловч үгийн эхний гийгүүлэгчийн зөрүүтэй байгаа нь асуудал болж байна.

Дээрх хоёр гурван үгийг шинжилж үзэхэд киданы хэл нь монгол язгуурын хэл болов уу гэж таамаглах нь эргэлзэх асуудлыг үлдээж байна уу гэсэн бодол төрж байна. Үүнээс гадна хэд хэдэн кидан үг нь монгол хэлний үгтэй тохирох боломжтой боловч кидан хэлний (五) (тав) гэсэн утгатай үг нь 「討」 гэсэн үг гэж бичсэн нь дээрх таамаглалыг дэвшүүлэх нэгэн хүчтэй үндэслэл болох боломжтой юм. Юун хэмээвээс түрэг язгуурын

<sup>1</sup> Мураямагийн дээр дурдсан өгүүлэл

<sup>2</sup> Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966.

<sup>3</sup> J.E.Kowalewski, *Dictionnaire Mongol-Russe-Français*, Kasan, 1844,

<sup>4</sup> Монгол хэлний *dayari-*, *toγuri-* зэрэг нь орчин цагийн монгол хэлэнд *дайр-* (*daira-*) , *тойр-* (*toiro*) болж байна. Гэвч *dayari-*, *toγuri-* нь зөв бичгийн дүрэм гэхээс илүү ерөнхий хөгжил нь *dāri-*, *tōri-* болж *daira-*, *toiro-* биш юм. Яагаад *daira-*, *toiro-* болсон бэ? Үүнийг дараах байдлаар тайлбарлаж болно. Энэ үгийн нууц товчооны хэлбэрээс харахад (秘) 答阿舌里-*daari-*. 脱斡<sup>舌</sup>里-*toogi-* байх агаад нууц товчооны аа, оо нь хараахан *ā*, *ō* гэсэн урт эгшиг болоогүй байна. Энэхүү аа, оо зэрэг нь хараахан hiatus-ын шатанд зүүн монголын хэлэнд 2-р үеийн эгшиг болон 3-р үеийн эгшиг авиа *i* - авиатай сэлгэх үзэгдэл явагдсан байна. Үүний дүнд *daari-*, *toogi-* нь *daira-*, *toiro-* болон хувирчээ. 1-р үеийн бус *i-* нь өмнөх үеийн эгшигтэй сэлгэх энэхүү үзэгдэл нь бусад аялгуунд ч нэлээд харагдаж байгаа бөгөөд жишээ нь: (mo.) *adali*: (mon.) *adal*<sup>a</sup>, (mo.) *boγoni*: (mon.) *bogino*, (mo.) *sōni*: (mon) *šinō*→*šōnō*-тэй адил байх нь нийтлэг байна. Одоо асуудал нь *tuγuli-*, *tuuli-* нь *dayari-*, *toγuri-* зэрэгтэй адил авианы бүтэцтэй байх боловч (mon.)-д туйл- (*tuilu-*) бололгүйгээр тууль болсон байна. Гэвч бичгийн хэлний хэлбэр өмнө нь *tuγuli-* байсан гэж үзвэл *tuγuli-*→*tuuli-*→*tuilu-* гэсэн хувиралт явагдах ёстой. Тэгвэл одоо тууль- (*tūli*) болох юм. Өмнө нь *tuγuli-* биш *tūli-* байсан учраас дээрх хувирлыг аваагүй гэж үзэж болох юм биш үү. Мөн бичгийн хэлний хэлбэр *tuuli-* гэдэг хэлбэр нь монголчуудын хэрэглэдэг толь бичигт тэмдэглэснээс үзэхэд энэхүү үг нь *tūli-* байсан гэх боломж өндөр гэж бодогдож байна. Гэвч энэ нь нэгэн таамагаас хэтрэхгүй гэдгийг л хэлмээр байна.

болон манж түнгүс язгуурын хэлэнд ч (五) (тав) гэсэн утгатай үг *tau~taw~tav*-тэй ойролцоо дуудлагатай үг байдаггүй, *tabu(n)~taw(an)* зэрэг хэлбэр нь зөвхөн монгол язгуурын хэлэнд байдаг юм.

Кидан үндэстний хэл нь дундад үеийн монгол хэлнээс өмнөх монгол хэл байсан гэж үзвэл кидан хэлийг монгол хэлний түүхийн талаас нь авч үзэх нь чухал гэдэг нь ойлгомжтой боловч одоогийн шатанд кидан хэлэнд үүнээс илүү гүнзгий орж чадахгүй байна. Кидан үсгийг тайлж уншихыг шаардаж буй учир шалтгааны нэг үүнд оршиж байна.

## 2. Дундад үеийн монгол хэл

2.1. 13-р зуунаас 16-р зууны сүүлч хүртэлх монгол хэлийг 「中世蒙古語」 (*middle mongolian*), өөрөөр хэлбэл дундад үеийн монгол хэл 「中期蒙古語」 гэж нэрлэдэг<sup>1</sup> боловч энэ үеийн монгол хэлэнд л тохиолдох хэд хэдэн фонемын онцлогийг үндэс болгон, энэхүү онцлог дээр зарим хэлний зүйн үзэгдлийг нэмбэл энэ үеийн монгол хэлийг дундад үеийн монгол хэлний эхэн үе 「前期中世蒙古語」, дундад үеийн монгол хэлний сүүл үе 「後期中世蒙古語」 гэж хоёр үед хувааж үзэх нь илүү тохирох болов уу гэж бодож байна. Мөн зөвхөн фонемын онцлогт тулгуурлан үзэх тохиолдолд түүний доод хязгаар нь 16-р зууны сүүлчийг 17-р зууны эхэн мөн дунд үе хүртэл доошлуулан үзэж болно.

13, 14-р зууны монгол хэлэнд үйл үгийн нөхцөлийн тогтолцоо, жинхэнэ нэрийн хүйс, тооны зохицолдоо, үйл үгийн үйлдүүлэх хэвийн нөхцөл *-lʰa-/-lʰe-* байхгүй байгаа зэрэг хэлний зүйн баримтын хувьд эртний монгол хэлээс уламжилж ирсэн гэх анхаарал татах онцлог тод үлдсэн байх боломжтой, мөн дээр дурдсан онцлогууд алдагдсан 15, 16-р зууны монгол хэлээс салган үзэх хэрэгтэй юм. Гэвч нөгөө талаар энэ үеийн монгол хэлний онцлогийг агуулсан фонемын онцлог, ялангуяа үгийн эхний *h* байгаа, нэгдүгээр үеийн эгшиг *i* болон *e* хадгалагдан, эгшиг авианы хооронд *-γ/-g-* сугарч, бүхий л байрлалд 「tʃ」, 「dʒ」 бий болж 17-р зууны эхэн үеийн дурсгалт бичгүүдэд ч мөн тэрхүү онцлогийн ихэнх нь хадгалагдсан<sup>2</sup> байна. Иймээс 13-р зуунаас 16-р зууны сүүлч өөрөөр хэлбэл 17-р зууны эхэн үе хүртэлх монгол хэлийг ихэнхдээ дундад үеийн монгол хэл 「中世蒙古語」 гэсэн нэрээр нэрлэх нь миний хувьд тохиромжгүй биш гэж үзэж байгаа боловч нарийвчлан үзвэл 13,14-р зууны дундад үеийн монгол хэлний эхэн үе 「前期中世蒙古語」 ба 15, 16-р зуун өөрөөр хэлбэл 17-р зууны эхэн үе хүртэлх монгол хэлийг дундад үеийн монгол хэлний сүүл үе 「後期中世蒙古語」 гэж нэрлэх ёстой болов уу гэж

<sup>1</sup>) N.Poppe, *Grammar of written Mongolian*, Wiesbaden, 1954

<sup>2</sup>) Энэ тухай дараагийн зүйлд дурдана.

бодож байна.

Дундад үеийн эхэн монгол хэл нь одоогоор монгол хэлний түүхийн судалгааны эхлэл болж, мөн энэ үеийн хэл нь хэрэглэгдэхүүний хувьд баялаг тул судалгаа нь харьцангуй өрнөж байгаа тул цаашид Дундад үеийн эхэн монгол хэлний олон онцлогийг судлан хайж дараа нь эдгээр олон онцлогт хамаарах үеийн хөгжлийг мөшгөн, энэ асуудалд анхаарлаа хандуулан монгол хэлний үе шатны өөрчлөлтийн ул мөрийг тоймлон үзэх нь зүйтэй юм.

## 2.2. Дундад үеийн эхэн монгол хэлний онцлог

Дундад үеийн монгол хэлний судалгааны хэрэглэгдэхүүн нь дээр дурдснаар ① Сонгодогийн өмнөхи үеийн бичгийн хэлний дурсгал, ② Ханз үсгийн монгол хэлний дурсгал, ③ Дөрвөлжин үсгийн монгол хэлний дурсгал, ④ Араб үсгийн монгол хэлний дурсгал зэргийг дурдсан бөгөөд Дундад үеийн өмнөх монгол хэлний судалгаа шинжилгээнд дээрх ②-г хамаарах дурсгал [元朝秘史] Нууц товчооны монгол хэл нь чанар хэмжээний хувьд бусдаас илүү үнэ цэнэтэй тул нууц товчооны хэлэнд тулгуурлан бусад дурсгалтай харьцуулан дундад үеийн эхэн монгол хэлний онцлогийг товч өгүүлье.

### ① Үйл үгийн нөхцөлийн тогтолцоо

Дундад үеийн өмнөх монгол хэлний үйл үгийн цагт нэрийн нөхцөл дараах тогтолцоотой байжээ.<sup>1</sup>

Тоо цаг	Эр хүйст ганц тоо	Эм хүйст ганц тоо	Олон тоо	Хүндэтгэлийн хэлбэр	Дарж доошлуулсан хэлбэр
Одоо цаг	-mu/-mü	-mi	-mui/-müi	--mui/-müi	-mu/-mü
	-yu/-yü	-yi	*-yui/-yüi	*-yui/-yüi	*-yu/-yü
	-u/-ü	-i	-ui/-üi	-ui/-üi	-u/-ü
			-ai/-ei		-ai/-ei
Өнгөрсөн болон төгссөн			-d		
	-ba/-be	-bi	-bai/-bei	-bai/-bei	-ba/-be
	-juγu/-jügü	-jigi;-jigei	-juγui/- jügüi	-juγui/-jügüi	-juγu/-jügü
	-luγa/-lüge	-lige;-liyi	-luγai/- lügei	-laγa/-lege	-luγa/-lüge
			-laγa/-lege	-laγa/-lege	-luγa/-lüge
Өнгөрөн төгссөн	-γa/-ge	-γai/-gei	*-gi	-γai/-gei	-γa/-ge

Орчин цагийн монгол хэлэнд үйл үгийн цагт нэрийн нөхцөлийг ийнхүү хүйс,

<sup>1)</sup> 小沢重男『中世蒙古語の動詞語尾の体系』言語研究、第40号、昭和36年



тоогоор ялган хэрэглэх үзэгдэл нэгэнт харагдахгүй учраас дээрх хүснэгтийн адил нөхцлийн тогтолцоо нь дундал үеийн эхэн монгол хэлний томоохон онцлог гэдгийг хэлэх хэрэгтэй юм. Эдгээр нөхцөлийн дотор ялангуяа хүйсээр ялган хэрэглэхдээ өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь эр үү эм үү гэдгийг мэдрэмжээрээ ялгаж байсан ба хэлний хэлзүйн онцлогоос шалтгаалан ялгаатай байсныг анхаарах нь зүйтэй юм. Мөн 「指上形」, 「指下形」 гэдгийг маш товчоор хэлбэл 「指上形」 нь өөрөөсөө ахмад хүний үйл хөдлөл, үйлдэлд хандсан нөхцөлийн хэлбэр бөгөөд 「指下形」 нь өөрөөсөө насаар дүү хүний үйл хөдлөл, үйлдэлд хандсан нөхцөлийн хэлбэр гэж хэлэх бөгөөд тодорхой зүйлийг 「言語研究、第 40 号」<sup>1</sup> Хэл шинжлэл сэтгүүлийн 40-рт гарсан өгүүлэлтэй харьцуулж үзвэл талархана. Доор дээрх нөхцөлийн хэрэглээний жишээний заримаас дурдья.

① (4.37.3,4) *Wang qan Ergune huru'u jamuqa-yi nekeba, Ānggīs qahan Onan jūg Taiičiud-un Auču Baatur-i nekeba.*

② (4.20.7) *Sača Taiču qoyar ugulerun ugulegsen uge-dur-iyen ba ese gurbai.*

③ (1.23.6) *tere dunda keelitai eme Bodunčar-tur ireju koulebi.*

④ (5.24.10~25.1) *Yesui qadun yekede seuurelbi.*

дээрхи жишээ нь зөвхөн өнгөрсөн цагийг илэрхийлэх нөхцөл *-ba/-be; -bai/-bei; -bi-ийн* жишээ байх агаад ① нь өгүүлэгдэхүүн нь эр хүйст ганц тоо, ② нь өгүүлэгдэхүүн нь олон тоо (*ba-* бид), ③ болон ④ нь өгүүлэгдэхүүн нь эм хүйст ганц тоо (*eme-女, gadun-*后) байна. Үйл үгийн нөхцлийн томоохон онцлог нь нууц товчооны монгол хэлэнд нэлээд тод үлдсэн байх агаад 1335 оны нанхиад монгол хадмал орчуулгатай хөшөөний бичигт 漢蒙對訳碑文<sup>2</sup> ч мөн *ögčigi, aǰgi* -тай адил *-ǰgi(-čigi)* гэсэн лавтай баримт байгаа тул 14-р зууны дунд үе хүртэл үйл үгийн нөхцлийг ялган хэрэглэх байдал хадгалагдаж байжээ гэж хэлж болно.

Мөн хүндэтгэлийн хэлбэрийн жишээг дурдья.

(4.19.8) *Ānggīs qahan jürkin-dur morilabai.*

энэхүү *morilabai*-гийн *-bai* нь *Ānggīs qahan* учраас олон тооны хэлбэр байх боломжгүй юм. Хэлбэрийн хувьд олон тооны *-bai*-тай адил боловч дээрх тохиолдолд олон тооны нөхцөл гэж зөвшөөрч болохгүй юм. *-bai*-г хүндэтгэлийн хэлбэр гэж үзэж байгаа тул өгүүлэгдэхүүн нь Чингис хаан болох тул ганц тооны хэлбэр *-ba* биш, хүндэтгэлийн хэлбэрийн *-bai*- гэсэн хэлбэрийг хэрэглэсэн байна.

## ② Жинхэнэ нэрийн тооны зохицол, жинхэнэ нэр бүтээх дагавар *-tu*-гийн тухай

<sup>1</sup>) 小沢重男、дээрх өгүүлэл

<sup>2</sup>) F.W. Cleavis, The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang. Ying-Jui, H. J. A. S. Vol.13, No.1 and 2, 1950.

Үйл үгийн нөхцөл нь өгүүлэгдэхүүний хүйс, тоогоор ялган хэрэглэж байсан дундад үеийн өмнөх монгол хэлэнд мөн жинхэнэ нэрд ч тодотгогч болон тодотгуулагчийн хооронд тооны зохицол илрэн гарч, мөн жинхэнэ нэр бүтээх дагавар *-tu/-tü-* г хүйс, тоогоор ялган хэрэглэж байжээ. Жишээ нь:

3.32.9 *nikan uċugan Kokoċu neretu koun-i* .....

1.49.3 *uċuged qoċoruqsad deu-ner-iyen*.....

*uċugan*, (*uċugen*) нь (ганц тоо), *uċuged* нь (олон тоо) нэр үг тодотгож байна. Энэхүү тохиолдолд *koun* ба *deu-ner* нь тооны хувьд тохирч, өмнөх нь ганц тооны хэлбэр *uċugan*, дараах нь олон тооны хэлбэр *uċuged* юм. Чухамдаа *qoċoruqsad*-ын *-qsad* ч мөн үйл үгийн өнгөрсөн цагийн дагавар *-qsan*-ны олон тооны хэлбэр агаад мэдээж *deu-ner*-тэй тохирсон хэлбэр юм. Дараа нь жинхэнэ нэрийн дагавар *-tu/-tü-* ын жишээг авч үзье.

① 1. 23.8. *Tere Jadaradai -in koun Tuguudai neretu bulee.*

② 1.41.5 *Hoelun aċin-eċe*..... *Temulun neretai nikan okin torebai.*

③ 1.7.3 *Alan qoa Dobun mergan-tur ireċu qoyar koun toreulbi.*

*Bugunutai Belgunutai nereten bulee.*

дээрхи 3 жишээ *neretu*, *neretai* (*neretei*), *nereten* нь *nere* гэх утга бүхий дагавар *-tu/-tü-* г дагуулсан хэлбэр юм. Тайлбараа ойлгомжтой болгохын тулд ①, ③, ② гэсэн дараалалтайгаар өөрчлөн бичиж үзэхэд

① *Tuguudai neretu koun*

② *Temulun neretai nikan okin*

③ *Bugunutai Belgunutai nereten qoyar koun*

болох бөгөөд *-tu/-tü-* нь эр үгийн ганц тооны хэлбэр *-tai/-tei-* нь эм үгийн ганц тооны хэлбэр, *-tan/-ten* нь олон тооны хэлбэр гэдэг нь тодорхой батлагдана. Энэ дагаврыг ялган хэрэглэсэн байдал нь нууц товчооны монгол хэлэнд тун тодорхой байна. Орчин цагийн монгол хэлэнд энэхүү дагаврын дээрхтэй адил хүйс, тоогоор ялган хэрэглэх ул мөр хадгалагдаагүй тасарч, зөвхөн *-tan/-ten-* г ихээр хэрэглэж, *-tu/-tü-* болон *-tan/-ten* нь зарим үгэнд нэлээд хуучирсан хэлбэрээр үлдсэнээс хэтрэхгүй байна. Яагаад *-tai/-tei-* нь өргөн хэрэглэгдэж, *-tu/-tü* хэрэглэгдэхээ болив? Мөн *-tai/-tei-* нь хэдий үеэс үүссэн гэх зэрэг асуулт гарах боловч энд үүнээс илүү гүнзгий орж чадахгүй байна.

### ③ Жинхэнэ нэрийн эс ялгах тийн ялгалын тухай

Орчин цагийн монгол хэл болон хэд хэдэн аялгуу жишээ нь буриад аялгуу, сахар аялгуунд үгийн үндсийн сүүлийн авиа *n~o-* той сэлгэх, хэсэг жинхэнэ нэрийн үндэс байдаг. Энэхүү *n~o-* той сэлгэх үзэгдэл дундад үеийн монгол хэлний эхэн шатанд нэгэнт байж тэр хэвээрээ хадгалагдсан гэж хэлж чадахгүй ч, орчин цагийн монгол хэлний олон

аялгуунд уламжлагдан ирсэн гэж хэлж болно. Гэвч энд асуудал болж буй зарим үгийн үндэс нь зарим байдлаар ялгаатай байна. Иймд Нууц товчооны монгол хэлэнд *n~o*-той сэлгэсэн мөртөө орчин цагийн монгол хэлэнд *n~o*- сэлгэдэггүй үндэс байдаг. Жишээ нь: орчин цагийн монгол хэлэнд охин, сайн, хан, хатан, хүн, иргэн, зэрэг үг нь *охин~охь, сайн~сай, хан~ха, хатан~хата, хүн~хү, иргэн~иргэ* гэж сэлгэдэггүй. Нууц товчооны монгол хэлнээс бид *oki, sai, qa, qatu, irge* зэрэг эцсийн *-n* үгүй хэлбэрийг олох нь тийм ч хэцүү зүйл биш юм. Иймээс адилхан *n~o*-той сэлгэх үндсэнд ч гэсэн Нууц товчооны монгол хэлний үеэс өнөө хүртэлх сэлгээнд харагдах үгийн үндэс, жишээ нь: *mori~morin, usu~usun* зэрэг Нууц товчооны монгол хэлэнд сэлгээ харагдах ба одоо энэхүү сэлгээ харагдахгүй үгийн үндэс, жишээ нь: дээрх *oki~okin*-оос ялгаж үзэх учиртай юм. Одоо өмнөхийг А үндэс, дараахийг В үндэс гэж нэрлэвэл В үндэс нь яагаад дараах үед *n~o*-той сэлгэхээ болиод *-n* үндэс болов гэсэн асуулт гарах болов уу. Энэ асуудлыг эсрэгээр нь авч үзвэл В үндэс нь *-n* үндэс болж тогтсон атал яагаад А үндэс нь *n~o*-той сэлгэх байдлаа хадгалж байна гэсэн асуулт гарна. Энэ тухай одоогийн монгол хэлний олон аялгуунд *-n* байгаа эсэхийг нухацтай судлах нь зүйтэй гэсэн сонирхолтой асуудал болгон дэвшүүлж байна. Ирээдүйд надад ч мөн энэ талаар ярих боломж олдох болов уу гэж бодож байна.

Мөн монгол хэлэнд *ус ууна, морь унана* зэрэг *ус, морь*-ийг нэрийн тийн ялгалын эс ялгах хэлбэрийн хувьд (*kasus indefinitus*), нэрлэхийн тийн ялгалын хэлбэртэй адил хэлбэр боловч нэрлэхийн тийн ялгалын үүрэг байхгүй тийн ялгал гэж нэрлэн *n~o*-той сэлгэх үгийн үндсэнд *-n* байхгүй хэлбэр, нэрлэхийн тийн ялгалтай адил хэлбэр нь нэрийн тийн ялгалын эс ялгах хэлбэр болон илэрч байгааг нэгэнт дурдсан тул<sup>1</sup> Нууц товчооны монгол хэлний доорх жишээг харж, *oki, qa, qatu* -г нэрийн тийн ялгалын эс ялгах хэлбэр гэж нэрлэхийг зөвшөөрөх болов уу.<sup>2</sup>

(1.34.5) *ter čag-tur Yesugai Baatar Onan muren-ne sibauulan yabuqui-dur Merkid-un Yeke Čiledu Olqunuud irgen-eče oki abču eusgeju aisuqu-i joluqaju onggeiju uјebesu ongge јisu busitai oki qatu uјejju gertur-iyān qarīn hauunlju.....*

(4.31.6) ... *јamuqa-i tende gur qa erguba. Gur qa ergued Činggis qahan Wang qan qoyar-tur morilaya keelduba.*

Гэтэл энд нэг асуудал байна. Нууц товчооны монгол хэлэнд

(1.46.3) *oki inu uјebesu niur-tur-iyān gereltei nidun-tur-iyān qaltai okin-i uјejju.....*

(1.32.10.33.1) .....*Tatar irgen-e Ambaqai qahan okin ogču oesun okin-iyān hudeju odqu bolun...*

<sup>1</sup>) N.Poppe, *Khalkha-Mongolische Grammatik*, Wiesbaden, 1951.

<sup>2</sup>) N.Poppe, *Die Sprache der Mongolischen Quadratschrift Yüan-chi'ao Pi-shi* Asia Major-Neue Folge 1944, 1, Helt

(1.33.6) *qamtuq-un qahan ulus-un ejen boluju oki-ben oesun hudekui-ben namaar kesedkun...*

дээрх жишээнд япон хэлний 《娘を~》 охиныг *oki uje-* 《娘を見る》, *okin-i uje-* 《娘を見る》, *okin og-* 《娘を与える》 *oki*, *okin*, *okin-i* зэрэг 3 хэлбэр бөгөөд *okin-ben* ба *okin iyen-*ийг нэмэхэд 5 болох боловч энэхүү 2 хэлбэрийг хойш тавих, *okin-i* нь заахын тийн ялгал гэдэг нь асуудалгүй боловч *oki-*ыг нэрийн тийн ялгалын эс ялгах хэлбэр гэж нэрлэвэл, дээрх тохиолдолтой адил *okin-*ыг бид юу гэж нэрлэвэл зохистой вэ? Орчин цагийн олон аялгуунд монгол хэл мэдээж, нэрлэхийн тийн ялгалын хэлбэр *-n-*ыг хадгалж байдаг буриад, халимаг аялгуунд ч жишээ нь: ус ууна, морь унана, мөн усан ууна, морин унана зэрэг нь байдаггүй. Ялангуяа дээрх *okin og-*тэй тохирох хэлбэр харагдахгүй байна. Гэвч нууц товчоонд үүнээс гадна (4.42.8) 秣<sup>舌</sup>麟兀訥阿<sup>傷</sup> *morin unuad* байх агаад (4.40.6) 兀孫 額<sup>舌</sup>里周 *usun eriju* ч харагдаж байна. Иймээс *oki*, *qa* нь өөрөөр хэлбэл зөвхөн *mori*, *usu* зэргийг эс ялгах хэлбэр гэж нэрлэн дээрх жишээтэй адил *morin*, *usun*, *okin-*ны талаар ямар нэгэн зүйл дурдаагүй нь дутуу мэт санагдана. Миний бие *morin* зэрэг хэлбэрийг заах тийн ялгал гэж нэрлэн *oki*, *qa* зэрэг эс ялгах хэлбэрээс ялгах нь зүйтэй байна. Мөн нэрийн тийн ялгалын эс ялгах хэлбэр, заах тийн ялгал, заахын тийн ялгалын илэрхийлэх утгын зөрүүтэй байдлын тухай миний бие өөрийн саналыг хэлэхээр бэлтгэж байгаа бөгөөд олон жишээ, тодорхой тайлбар шаардагдах тул энд хүрээд зогсоё.

#### ④ Үйл үгийн үйлдүүлэх хэвийн нөхцөл *-lya-/-lge-* болон үйл үгийн нөхцлийг угсран залгах дараалал

Сонгодог бичгийн хэл болон орчин цагийн монгол хэлний олон аялгуунд байдаг үйлдүүлэх хэвийн нөхцөл *-lya-/-lge-* нь нууц товчооны монгол хэлэнд жишээ огт байхгүй байгаа нь тодорхой баримт юм. Жишээ нь:

бичгийн хэл	монгол хэл	нууц товчооны монгол хэл
<i>sayalγa-</i>	<i>саалга</i>	<i>saaul-</i> (撒阿兀 <sup>勒</sup> )
<i>jögelge-</i>	<i>зөөлгө</i>	<i>jöeul</i> (額兀 <sup>勒</sup> )
<i>kilge</i>	<i>хийлгэ</i>	<i>kiul</i> (乞兀 <sup>勒</sup> )
<i>iniyelge</i>	<i>инээлгэ</i>	<i>ineeul</i> (亦捏額兀 <sup>勒</sup> )

байх агаад бичгийн хэл болон монгол хэлэнд *-lya-/-lge-* (-лга-/ -лгэ-/ -лгө / -байгаа бол нууц товчоонд ямагт *-ul-* (бичгийн хэлний *-γul-/-gül-*) илэрч байдаг. Энэ нь нууц товчоо бичигдсэн 13-р зууны дунд үеийн монгол хэлэнд *-lya-/-lge-* байгаагүй гэдгийг өгүүлж байна. *-lya-/-lge-* нь дурсгал бичгүүдэд анх нотлогдсон нь 1335 оны нанхиад монгол хадмал орчуулга бүхий чулууны бичиг (漢蒙対訳碑石) байсан бөгөөд, 1389

оны бүтээл болох 華夷訳語甲種本-нд мөн *-lʎa-/-lge-* тэй үг байгаа нь нотлогдсон юм.

Ийнхүү 14-р зууны дунд үед анх удаа *-lʎa-/-lge-* илрэн гарсан нь энэ үед монгол хэл, зарим аялгуунд үүсмэл урт эгшиг хэвшин тогтож эхлэснийг баталж байна. Тэгвэл *-lʎa-/-lge-* байхгүй Нууц товчооны хэлэнд үүсмэл урт эгшиг хараахан үүсээгүй гэдгийг хэлж болно.

Энэхүү *-lʎa-/-lge-* байгаагүй, үүнтэй зэрэгцээд нэгэн сонирхолтой үзэгдэл бол үйл үгийн олон нөхцөлийг үгийн үндсэнд угсруулан залгах дараалал юм. Энэ талаар тодорхой өгүүлэхэд нэлээн сунжрах тул зөвхөн дараах зүйлийг авч үзье. Сонгодог бичгийн хэлний *bicigdegül-* ийг *bici-gde-gül-* гэж задалж болох бөгөөд *-gde-* нь үйлдэгдэх хэвийн нөхцөл, *-gül-* нь үйлдүүлэх хэвийн нөхцөл болно. Мөн монгол хэлэнд *бичигдүүл* нь *бичи-гд-үүл* болох бөгөөд нөхцлийг үгийн үндсэнд залгах дараалал нь бичгийн хэлний адилаар үгийн үндэс+үйлдэгдэх хэвийн нөхцөл+үйлдүүлэх хэвийн нөхцөл гэсэн дараалалтай байна. Гэвч нууц товчооны монгол хэл, сонгодгийн өмнөх бичгийн хэл нь сонгодог бичгийн хэл, монгол хэлнээс ялгаатай, жишээ нь : (兀窟兀勒迭) *ukuulde (uku-ul-de)* , *uqayulda (uqa-yul-da)* -аас мэдэж болох бөгөөд үгийн үндэс + үйлдүүлэх хэв+үйлдэгдэх хэвийг зааж байна. Энэ нь дундад үеийн эхэн монгол хэлний нэгэн онцлог гэж үзэх ёстой юм.

Дээрх хэдэн зүйлээр дундад үеийн эхэн монгол хэлний онцлогийг товч дурдсан бөгөөд энэхүү дундад үеийн эхэн монгол хэл нь дундад үеийн дараах монгол хэлний шатанд зууч болж, шинэ үеийн монгол хэлэнд шилжжээ. Энэхүү шилжилтийг энэ удаа фонемын үзэгдлийн талаас голлон авч үзье.

### **3. Дундад үеийн монгол хэлнээс шинэ үеийн монгол хэлд шилжсэн нь**

3.1. Дундад үеийн эхэн монгол хэлэнд фонемын бүтэц, хэлзүйн байгуулал болон үгийн сангийн хувьд эртний монгол хэлнээс өвлөж авсан ул мөр тодорхой илэрч байх бөгөөд 15, 16-р зууныг дамжин 17-р зуун болоход өмнөх зүйлд дурдсан онцлогууд тохиолдохгүй болж, фонемын хувьд дундад үеийн монгол хэлний зарим онцлогийг үлдээсэн ч бүхэлд нь авч үзвэл, шинэ үеийн монгол хэлний дүр төрхтэй хэл болж гарч ирсэн юм.

Монгол үндэстний түүхэнд 1368 оны Юань гүрэн задран унаснаас хойш, 17-р зууны дунд үед Чин улсын ноёрхолд орох явц нь Монгол үндэстэн тэдгээрийн өөр хоорондоо тэмцэлдэж эхэлсэн үе байсан ба тиймдээ ч гэх үү 15-р зууны сүүлийн хагасаас 16-р зууны сүүл хүртэл монгол хэлний сурвалж бичгүүд ховор, дундад үеийн дараах монгол хэлний ерөнхий тойм тодорхой биш байгаа нь хүндрэлтэй юм. 17-р зуун болсон ч бидэнд аман ярианы хэрэглэгдэхүүн бараг байхгүй боловч, бичгийн хэлний

хэрэглэгдэхүүн улам арвин болж ирсэн юм. Тэдгээр бичгийн хэрэглэгдэхүүн болон зарим аман ярианы хэрэглэгдэхүүнтэй харьцуулж судалсанаар 17-р зуунаас хойших монгол хэлэнд, дээр дурдсан дундад үеийн эхэн монгол хэлний олон онцлогууд алдагдсаныг мэдэж болох тул 15-р зуунаас 16-р зууны хооронд хэлзүйн байгуулалд өөрчлөлт гарсныг олж мэдэж болно. Үйл үгийн дагаврыг хүйс, тоогоор зохицуулан хэрэглэх зэрэг хэлзүйн онцлог алдагдсан боловч 17-р зууны эхний хагасын монгол хэл нь фонемын хувьд дундад үеийн монгол хэлний онцлогууд хараахан алдагдаагүй байна.

3.2. Дундад үеийн монгол хэлний авиалбарын онцлогийг шинэ үеийн монгол хэлтэй харьцуулж үзэхэд:

- ① Үгийн тэргүүнд *h*- хадгалагдаж байсан
  - ② *i* –ийн нугарал хараахан үүсээгүй ба үгийн тэргүүн үеийн *e*- нь өөр эгшигт хувираагүй
  - ③  $v+\gamma(g)+v$  –ээс үүссэн үүсмэл урт эгшиг хараахан үүсээгүй
  - ④ бүхий л эгшгийн өмнө *č* (*ʃ*), *ʃ* (*ʧ*) хадгалагдаж байсан
- дээрх 4 зүйлд хуваан үзэж болно. Тус бүрт зарим жишээ авч үзье.

① Үгийн тэргүүний *h*. Монгол хэлэнд энэхүү *h*-г тэмдэглэх үсэг байхгүй, тиймд сонгодгийн өмнө монгол бичгийн хэлэнд *h*-г тэмдэглээгүй байна. Иймээс *h*-г бусад сурвалж бичгүүд, ханз үсгээр тэмдэглэсэнийг монгол хэлний дурсгал, дөрвөлжин үсгийн монгол хэлний дурсгал зэргээс олж мэдэж болно.

(秘) 合<sup>𐰽</sup>兒班 *harban* (+) (pa.) *harban* (mu.)<sup>1</sup> *harban*

(秘) 桓 *hon* (年 (pa.) *hon* (mu.) *honu* (*hon-u*) (年の)

② Үгийн тэргүүн үеийн *i*, *e*. Орчин цагийн монгол хэлний олон аялгуунд тэргүүн үеийн *i*- нь өөрөөр хэлбэл *i*- ийн нугарлыг үүсгэж, *i*-нь тэр хэвээрээ хадгалагдаагүй гэдгийг мэдэж болно. Дундад үеийн монгол хэлэнд *i*-нь тэр хэвээрээ хадгалагдаж, *e* –нь өөр эгшиг авианд хувираагүй байна.

(mon.) *mingyan* (千) (秘) 敏<sup>𐰽</sup>罕 *minqan* (pa.) *miŋqan* (mu.) *minqan*

(mon.) *мянга* (*n*) (mo.) *miqa* (*n*) (肉) (秘) 米<sup>𐰽</sup>罕 *miqan* (mu.) *miqan* (mon.) *max* (*an*) (mo.) *ebedčin* (病氣) (秘) 厄別臣<sup>~</sup>厄別<sup>𐰽</sup>臣 *ebečin~ebedčin* (pa.) *ebečin* (mu.) *ebečin* (mon.) *өвчин*

③  $v+\gamma(g)+v$ . Орчин цагийн монгол хэл жишээ нь: монгол хэлний уул гэх утгатай үг нь  $\tilde{u}l^a$  (уул) бөгөөд монгол бичгийн хэлний утга нь *aγula* юм. Дундад үеийн монгол хэлэнд (秘) 崑崙刺峇 *aula*, (pa.) *a'ula*, (*ib*)<sup>2</sup> *aūla* байх тул яг бичгийн хэлний *aγula*- аас одоогийн  $\tilde{u}l^a$  болох завсрын шатыг харуулсан гэж үзэж болно. *aγu* нь  $\tilde{u}$  гэх урт эгшиг

<sup>1)</sup> Н.Роппе, *Монгольский словарь Мухаддимат Але-адаб*, Москва 1938.

<sup>2)</sup> Н.Роппе, *Монгольский словарь Мухаддимат Але-адаб*, Москва 1938.

болоогүй, *au-* тай адил hiatus-ын шатанд байжээ. Монгол бичгийн хэл нь фонемын түүхэндээ дундад үеийн монгол хэлнээс нэг үеийн өмнөх эртний байдлаа хадгалан үлдсэн нь энэ жишээнээс мэдэж болно.

④ Одоогийн монгол хэл болон халимаг аялгуу зэрэгт *цад-*, *чад-*, *tsad-*, *tšad-* тай адил *ts-* нь *f-*тай эсрэгцэж байгаа боловч дундад үеийн монгол хэлэнд энэ ялгаа үгүй болж, хоёулаа *čad-* [*fad-*] , *čida-* [*fida-*] болж, зөвхөн [*f*] болсон байна. Мөн дуутай авианы хувьд ч мөн адил бөгөөд одоогийн [*dz*],[*ɟ*] эсрэгцэлгүй, зөвхөн [*ɟ*] болжээ. Жишээ нь [秘] 札峇 *jada* (風雨) ; 只峇 *jida* (槍) -тай адил юм.

3.3. Дундад үеийн энэхүү 4 фонемын онцлог нь хэдий үеэс алдагдаж эхэлсэн бэ, өөрөөр хэлбэл фонемын тухайд шинэ үеийн монгол хэлэнд хэзээнээс илэрч эхэлсэн бэ гэдэг нь дараагийн асуулт болно. 15-р зуунаас 17-р зууны эхний хагас хүртэл монгол хэлээр тэмдэглэсэн дурсгалууд хамгийн ховор болохын дээр дурдсан асуултыг тодорхой болгоход ашиглаж болох дурсгалууд маш цөөн байх боловч Мингийн (明永樂)-ны 5-р он (1407) -нд бичсэн 華夷訳語(乙種本) , барагцаалвал 16-р зууны дунд үед зохиосон 華夷訳語(丙種本) -ийн 韃靼館, 16-р зууны сүүлч 登壇必究 өөрөөр хэлбэл 武備志 зэрэг монгол нанхиад хадмал орчуулгын үгийн сан 蒙漢対訳語彙, мөн Мингийн 38-р он (1610 он) 盧竜塞略 зэрэгт буй хадмал орчуулгын үгийн санг жишээ болгож болно. Мөн 1648 онд ойрадын Зая бандидын зохиосон Тод үсэг,<sup>1</sup> 1686 онд халхын Занабазарын зохиосон Соёмбо үсгийн<sup>2</sup> дурсгал, түүнээс гадна 15-р зууны араб үсгээрх монгол хэлний дурсгалууд нь томоохон лавлах хэрэглэгдэхүүн болно.<sup>3</sup> Дээрх олон хэрэглэгдэхүүнээс өмнө дурдсан 4 зүйл, түүний дараах хөгжлийг нягтлан үзэж болно.

① Үгийн эхний *h*

(華·乙)火敦 *hodun* (星) (華·丙)火敦 (登)<sup>4</sup>火敦 (武)<sup>5</sup>火敦(我度)

(盧)<sup>6</sup>火敦

(華·乙)許孫 *hüsün* (毛) (武)忽速(髮)、五素(頭髮) (盧)許孫

(華·乙)哈兒班 *harban* (十) (華·丙)蛤兒班 (武)哈兒八 (盧)哈兒霸

дээрх үгнээс харахад 1610 онд (盧) *hodun*, *hüsü*, *harba* зэрэг байх бөгөөд 17-р зууны эхэн үед *h-* нь одоо ч гэсэн хадгалагдаж үлдсэн болов уу гэж бодогдож байна. Гэвч эдгээр ханз үсгээрх монгол хэлний хэрэглэгдэхүүнийг тэмдэглэх арга нь уламжлагдаж

<sup>1) 2)</sup> Тод болон соёмбо үсгийн тухай Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*. Улаанбаатар, 1964.

G. 'Kara, *Un texte mongol en écriture soyombo*, Acta Oriental, Vol.9, 1959.

<sup>3)</sup> L.Ligeti, *Un vocabulaire mongol d'Istanbul*. Acta Oriental, Vol. 14, 1962.

<sup>4) 5)</sup> 「登壇必究, 武備志」所収の語彙は“金芳漢、漢・蒙対訳語彙集研究”による

<sup>6)</sup> 「盧竜塞略」所収の語彙は”石田幹之助、「盧竜塞略」に見えたる漢・蒙対訳語彙に就いて“蒙古学第二冊、昭和13年

тогтсон тал олон харагдах бөгөөд тэр үеийн аман аялгууны дуудлагаар тэр хэвээр нь буулгасан эсэх нь эргэлзээтэй газрууд байх ба, мөн 我度 *odo*, 五素 *üsü* зэрэг *h*-ийн сугарсан хэлбэр тэмдэглэгдсэн байх агаад (盧) -д үүнээс гадна 委亦 *oii*, 兀格兒赤 *ugerči*, 兀塔速 *utasu*, 五毒戶 *utuku* зэрэгт *h*- гээгдсэн байна. Дээрх үгийн дундад үеийн хэлбэр нь *h*- г авсан байгаа нь олон үгэнд харагдаж буй тул, 17-р зууны эхэн үед *h*-ийн сугарах явц нэлээд эрчимтэй явагдаж байсан үе байсан юм биш үү хэмээн бодож байна.

② Үгийн тэргүүн үеийн *i* ба *e*. Доор дурдах зүйлээс харахад 17-р зууны эхэнд нэгдүгээр үеийн *i* ба *e* нь хадгалагдаж байсан жишээ олон тохиолдох ёстой болов уу.

(華·乙) 石巴兒 *sibar* 《泥》(登) 失把兒 (武) 失把兒 (盧) 失喇 一曰石巴兒

(華·乙) 赤刺温 *čilaun* 《石》(登) 赤老文 (武) 赤老文 (扯勞) (盧) 赤刺温、扯勞、赤勞

(華·乙) 米罕 《肉》(華·丙) 米罕 (登) 米合 (武) 米合 (盧) 米罕

(華·乙) 你敦 *nidün* 《目》(華·丙) 你敦 (登) 你堵 (武) 你堵 (努都) (盧) 你敦

(華·乙) 失敦 *sidiün* 《齒》(華·丙) 失敦 (登) 失堵 (武) 你堵 (鼠都) (盧) 失敦

дээрхийн адил нэгдүгээр үеийн *i*-нь нугараагүй байгаа нь нийтлэг байна. Гэвч дээр бичсэн тэр хэвээр нь авч үзэж болохгүй гэж үзэж байна. Дээрх жишээнээс үзэхэд *i*-нугарсан 努都 *nüdü*n, 鼠都 *šüdü*n зэрэг тохиолдож, мөн 17-р зууны дунд үе хүртэлх бүтээл гэгдэх Altan Tobči 《黄金の史綴》-д бичгийн хэлний *šibtura*- 《ずり落ちる》, *čičuγ-a* 《鞭》, *šingqur* 《秃鷹》-ийн тухайд *šibtura*-, *čičaya*, *šongqur* харагдаж байна. Иймээс *i*-ийн нугарах үзэгдэл 17-р зууны эхэн үед нэгэнт эрчимтэй явагдсан гэж үзэх ёстой ба баруун монголын хэлэнд 15-р зууны дунд үеэс *i*-ийн нугарал эхэлсэн ч гэж үзэж болно.<sup>1</sup>

Нөгөө талаар 1686 оны соёмбо үсгийн дурсгалд *i*-ийн нугарсан хэлбэр харагдахгүй байгаа тул зүүн монголын хэлэнд *i*-ийн нугарал явагдаж тогтсон нь 18-р зуунаас хойш гэж бодож байна.

Үгийн тэргүүн үеийн *e*-ийн тухайд ч нөхцөл байдал бараг адил бөгөөд тэмдэглэсэн байдлаас харахад хараахан өөр авиа болж хувирсан зүйл харагдахгүй байна.

③ Дараа нь дундад үеийн *aa*, *au*, *eü* зэрэг *hiatis* нь 17-р зууны эхэн үед ямар байдалтай байсныг авч үзье.

Юуны өмнө *aa ee*-тэй адил өмнөө болон ардаа адилхан эгшигтэй байх тохиолдол байдаг. Үүнийг бүрэн урт эгшиг болсон гэж үзэж болно. Жишээ нь: (華·乙) 阿阿兒赤 *aarči* 《熬酪》, (秘) 額箴額 *emeel* (鞍), (華·乙) 兀主兀兒 *üjüür* 《梢》 зэрэг байгаа бол (盧) (武) (登) нь 阿兒赤, 額墨兒, 兀軸兒 харагдаж, энэ нь *ārči*, *emēl*, *üjül* гэдгийг

<sup>1</sup>) L.Liget, Un vocabulaire mongol d'Istanboul -аас үзэхэд 15-р зууны дунд үед *camayı*, *šinaJı*-ийн бичгийн хэлбэр *camayı*, *šinaJı* гэж тохиолдож байна. Араб үсгийн дурсгалуудад тэр үеийн баруун монголын хэлээр буулгасан байна.



илэрхийлж байна гэж бодож байна. Үүнээс гадна бичгийн хэлний *tügükei* (生の)、*čayajidu* (向うの)-нь (武)土虧、又只得 байх агаад энэ ч *tūkei čäjǰidu*-ийг илэрхийлж байна. Мэдээж (武) нь 米納阿 *minaa* (鞭), 帖額 *tee* (運ぶ)、補答安 *budaan* (飯) ч тохиолдох боловч эдгээр нь ч *minä, tē-, budä(n)* зэргээр дуудагдаж байгаа нь (武)米納, 補答-аас харахад тодорхой байна гэж хэлж болно.

Дараа нь *au, eü* мэт өмнөх болон дараах эгшиг өөр байх тохиолдол байна. Энэ тохиолдолоос үзэхэд хараахан урт эгшиг үүсээгүй гэж хэлж болох боловч жишээ нь: 赤刺温 *čilaun* (石), 撒察兀 *sacau* (同じ), 乞刺兀 *kilau* (霜) байгаа бол урт эгшиг үүсэх үзэгдэл улам эрчимжиж байгааг үзүүлэх 赤勞 *čilau*, 撒朝 *sačau*, 克勞 *kilau* зэрэг тохиолдож байна. Мөн дундад үеийн хэлбэр 糶兀-*neiü* (移る), 只羅阿 *jiloa* (手綱), 多舌羅額 *döröe* (あぶみ) байгаа бол 努巴 *nüba* (移った), 只羅 *jilo*, 堵勒 *düre* илэрч байгаагаас харахад энэхүү 3 хэлбэр *nü, jilō, dürē-* г илэрхийлж байгаа гэж бодогдож байна. *au, eü-* ийн хувьд ч урт эгшиг үүсэх үзэгдэл явагдсан нь тодорхой байна. Соёмбо үсгийн дурсгалд *ǰaura, iǰaur, sakiusu, čilgan* зэргийг хүлээн зөвшөөрч байгаа учраас зүүн монголын хэлэнд урт эгшиг үүссэн нь миний бодоход 17-р зууны сүүлч эсвэл 18-р зууны эхэн үе болов уу.

④ Дундад үеийн монгол хэлний *či[fi], ji [čji]*-ээс гадна *ča, ǰa, čo, ǰo* зэрэг нь орчин цагийн монгол хэл болон халимаг аялгуу зэрэгт *ца (tsa), за (dza), цо (tso), зо (dzo)* болж хувирсан боловч энэхүү хувирал хэдий үед үүссэн, энэ хувирах үзэгдэлийг дундад үеийн монгол хэлийг шинэ үеийн монгол хэлээс ялгах нэгэн онцлог гэж үзвэл энэ цаг үеийг тогтоох нь чухал юм.

Нэг үгээр хэлбэл нанхиад монгол хадмал орчуулгын үгийн сан, монгол хэлэнд тохиолдох *fā>tsa, čǰa>dza*-гийн хувирал 17-р зууны эхээр үүссэн эсэх нь бүрхэг байгаа юм. 盧竜塞略-ын монгол хэлний хэв шинж нь голдуу өвөр монголын нутгийн аялгууны хэлээр тэмдэглэсэн бөгөөд, өвөр монголын хэл жишээ нь: цахар аялгуу, ордос аялгуу зэрэгт одоо ч *f>ts, čǰ>dz*-ийн хувирал үүсээгүй хэл тул энэ асуудлыг нягтлах хэрэглэгдэхүүн болно гэж хэлэхэд хэцүү юм. Иймээс зөвхөн энэ хэрэглэгдэхүүнээс дүгнэлт гаргах нь эрсдэлтэй юм. 1648 оны тод үсэг нь тэр үеийн баруун монгол хэл, ойрд аялгууг тэмдэглэхийн тулд зохиогдсон үсэг бөгөөд тод үсгийн дурсгалуудад жишээ нь: бичгийн хэлний *čay* болон *čig*-ийн *č, jel* болон *jil*-ийн *j* -г тус тус өөр үсгээр ялган тэмдэглэсэн байдаг. Ялангуяа *tsay, fǰig, dzel, čsil*-тэй адил юм. Энэхүү баримт нь баруун нутгийн аялгуунд тэр үед *f>ts, čǰ>dz* хувирал үүссэн гэдгийг тусгаж байгаа биш үү. Зүүн монгол хэлэнд энэхүү хувирлын цаг үеийг таамаглах хэрэглэгдэхүүн цөөн боловч дээр дурдсан соёмбо үсэг нь *f>ts, čǰ>dz* -ийн хувирлыг харуулж байгаа тул 17-р зууны эцэст энэхүү хувирал үүссэн гэж үзэх ёстой болов уу.

3.4 Дээр дурдсан зүйлийг бодож үзэхэд фонемын тухайд дундад үеийн онцлог нь 17-р зууны дунд үеэс сүүл үе хүртэл үргэлжилсэн гэж бодогдох бөгөөд, зөвхөн энэ зүйлийн тухайд дундад үеийн монгол хэл, шинэ үеийн монгол хэлний уулзварыг 17-р зууны сүүлчээс хайх ёстой болов уу гэж бодогдоно. Гэвч өмнөх зүйлд дурдсан хэлзүйн үзэгдэлтэй холбоотой дундад үеийн онцлог нь лавтай 16-р зууны сүүл үе хүртэл бүрэн алдагдсан гэж үзэх ёстой тул дээр тэмдэглэсэн фонемын хувирал нь ч гэсэн 17-р зууны эхэн үед нэгэнт явагдаж байсан гэдэг нь нэлээд эргэлзээтэй тул энэ 2 зүйлийг нэгтгэн үзэж дундад үе болон шинэ үеийн уулзварыг 16-р зууны сүүлч өөрөөр хэлбэл 17-р зууны эхний хагасаас хайхыг зөвшөөрөх ёстой юм.

**4.1 Шинэ үеийн монгол хэл.** 17-р зууны эхэн хагасаас одоо хүртэлх монгол хэлийг шинэ үеийн монгол хэл гэж үзэж, 13-р зууны өмнөх монгол хэлийг эртний монгол хэл гэж үзвэл монгол хэлний түүхийг эртний монгол хэл, дундад үеийн монгол хэл, шинэ үеийн монгол хэл гэж гурван томоохон хэсэгт хувааж болно. Өнөө хүртэл туйлын дутагдалтай боловч, дундад үеийн монгол хэлнээс эхлэн монгол хэлний өөрчлөлт хувирлыг судалж ирсэн бөгөөд энд шинэ үеийн монгол хэлний талаар дурдах дараалал болж байна.

17-р зууны тухайд он дараалал нь тодорхой болсон дурсгал бичгүүдтэй танилцах боломжтой болсон ба тэр үеийн монгол бичгийн хэлний тухай ойлгож мэдэж чадсан боловч, аман ярианы хэл нь бичгийн дурсгалуудад цухас дурдагдах ярианы хэлний элементээс тэр үеийн аман ярианы хэлний ерөнхий агуулгыг таамаглахаас хэтрэхгүй байна.

Гэвч, бид орчин цагийн монгол хэл болон хэд хэдэн монгол хэл аялгууны тухай мэдлэг, 17-р зуун хүртэлх монгол хэлний тодорхой хэмжээний ойлголтыг нийлүүлээд мөн 18-р зууны дунд үе болоход солонгос хэлний монгол хэлний дурсгал (諺文蒙古語文獻)<sup>1</sup>, манж үсгийн монгол хэлний дурсгал (滿州字蒙古語文獻)<sup>2</sup> гарсан тул, эдгээр ойлголтыг нэгтгэн 17-р зууны дунд үеэс хойш 18, 19-р зууны монгол хэлийг нийтэд нь авч үзвэл ямархуу хувьсал, хөгжлийн зам туулсныг таамаглах боломжтой болно. Энэ үүднээс авч үзвэл, 17, 18, 19-р зуун болон 20-р зууны эхэн хүртэлх монгол хэлний ерөнхий дүр зургийг бодож үзэхэд, доорх хэдэн зүйлийг хэлж чадна гэж бодож байна.

Эхлээд фонемын хувьд энэ үеийн монгол хэл болон олон аялгуунд

<sup>1</sup> 諺文蒙古語文獻には、「蒙語老乞大」、「捷解蒙語」、「蒙語類解」があり、李基文、(蒙語老乞大)研究、震檀学邦 25, 6, 7 合併号; 菅野裕臣、「捷解蒙語」朝鮮学報27;

“小沢重男、中・韓・蒙対訳語彙集「蒙語類解」東京外国語大学論集“などの研究が見られる。

<sup>2</sup> 滿州字蒙古語文獻には「三合語録」「三合便覧」「滿州蒙古兼清文鑑」「御製滿珠蒙古漢字三合切音清文鑑」などが見られる。

① үгийн тэргүүнд байх *h*- бүрэн сугарсан. (дагуур аялгуу болон бусад хятад улсын хил орчмын бүс нутгийн зарим аялгуунд одоо ч хадгалагдан үлдсэн байх)

② hiatus –ийн байдалтай байсан хоёр эгшиг бүрэн урт эгшигт хувирсан.

③ *i*-ийн нугарал болон үгийн тэргүүн үеийн *e*- нь бусад эгшигт хувирах үзэгдэл гарсан.

④ дундад үеийн монгол хэлний *tʃ*, *ʧ* нь зарим аялгуунд *i*-ээс бусад эгшигийн өмнө *ts*, *dz*-д хувирчээ.

Мөн өвөрмонголын цахар аялгуу, ордос аялгуунд энэ хувирал гараагүй байна. Мөн буриад аялгуунд улмаар *ts>s*, *tʃ>ʃ*-д хувирч, үүний дүнд *s>h*-ийн хувирлыг үүсгэжээ.

дээрх олон хувирал өөрчлөлт гарсныг бид мэдэж болно. Дараа нь морфемын хувьд энэ хугацаанд олон үзэгдэл гарчээ.

① үйл үгийн одоо, ирээдүй цагийн нөхцөл *-na/ ne* бий болсон

② жинхэнэ нэрийн хувилгах нөхцөл энэ үеийн өмнөх үе, 18-р зууны сүүл хүртэл одоогийн хэлбэртэй ойролцоо болсон байна. 17-р зууны дунд үеийн дурсгал болох Altan Tobči –д

*Ögelen ekese Tatar Temüjin-i talaγa talaji irekü-dü negen noγun köbegün törbe.*

гэх өгүүлбэр байх агаад бид энэхүү өгүүлбэрээс дараах зүйлийг ойлгож чадна.

1. *ekese*-ээс орчин цагийн гарахын тийн ялгал *-ēs*-ийг амархан таамаглаж болно. Энэ нь *eke-eče>ekēče>ekēse>ekēs* (эхээс) *ekēče*-ийн үе шатыг тэмдэглэсэн гэж бодож байна.

2. *talaji* нь бичгийн хэлний *-ju/- jü* нь нэгэнт аман ярианд *-ji*-д хувирсныг таамаглана.

3. *irekü-dü* нь орчин цагийн *ирэхэд* гэдэг үгийн өмнөх хэлбэр. Аман ярианд өгөх оршихийн тийн ялгалын нөхцөл тэр үед *-du/- dü* байсан биш үү.

Үүнээс гадна *Altan Tobči*-д тэр үеийн аман яриаг буулгасан гэх хэлбэр олон газар тохиолдох ба жишээ нь: бичгийн хэлний *irelüge* нь *irelē*, *minü* нь *mini* зэрэг байх агаад эдгээрийг нэгтгэн үзэхэд орчин цагийн монгол хэлний араг яс 18-р зууны дунд үеэс сүүл үе хүртэл бүрэлдсэн гэж үзэж байна.

**4.2. Орчин цагийн монгол хэл.** Орчин цагийн монгол хэлний тухайд намайг монгол хэл сурч эхэлсэн 1944 оны өвөр монголын сонин, өвөр монголын өдрийн мэдээний монгол бичгийн хэл болон сүүлийн үеийн өвөр монголд хэвлэгдсэн бүтээлийн монгол бичгийн хэлтэй харьцуулан үзэхэд ямар нэгэн ялгаа гарах тул орчин цагийн монгол хэлний орчин цаг нь ихээхэн цаг хугацааг хамарсан үе юм. Энэ утгаараа орчин цагийн монгол хэлний тухай бодоход 1921 оны ардын хувьсгалын дараах монгол хэлийг Орчин цагийн монгол хэл гэж нэрлэвэл ямар бол гэж бодогдож байна. Өөрөөр хэлбэл 1941 оны

Бүгд Найрамдах Монгол Ард Улсад үсэг бичгийн өөрчлөлт гарсны дараах монгол хэлийг орчин цагийн монгол хэл гэж нэрлэх боломжтой болов уу. Аль нь ч бай одоогоос тийм ч хол биш өнгөрснөөс одоо хүртэлх монгол хэлийг ингэж нэрлэмээр байна.

Орчин цагийн монгол хэлэнд дундад үеийн монгол хэлний онцлог тод үлдсэн хэдэн онцлог аялгуу болон энэхүү онцлогоос сугарч хөгжсөн монгол хэл, буриад аялгуу, халимаг аялгуу, өвөр монголын аялгуунууд зэрэг аялгуунууд багтах бөгөөд бичгийн хэлний хувьд өвөр монголын өөртөө засах орны монгол бичгийн хэл ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсад хэрэглэж буй монгол бичгийн хэл, улмаар 1945 оноос хойш Шинжаан Уйгарын өөртөө засах орны ойрдуудын хэрэглэх тод үсгийн бичгийн хэлийг дурдаж болно.

Орчин цагийн монгол хэлэнд монголчуудын албан ёсны хэлний үүргийг гүйцэтгэж байгаа нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсад хэрэглэгдэх халх монгол хэл бөгөөд энэхүү хэл нь орчин цагийн монгол хэлний дотроос хамгийн шалгарсан хэл, тодорхой зөв бичгийн дүрэм, баялаг үгийн сан бүхий орчин цагийн хэл юм.

Сүүлийн үед орос хэлнээс үг зээлдэн хэрэглэх байдал харагдах боловч монголчууд монгол хэлээ нандигнан үздэг үндэстэн тул урьд өмнө нь монгол хүмүүсийн дунд байгаагүй шинэ ойлголтыг илэрхийлэхдээ гадаад үгийг шууд хэрэглэлгүй боломжийн хирээр өөрийн хэлээр шинэ ойлголтыг илэрхийлэх үгийг бодон олж байна. Жишээ нь: одон ба дуран гэдэг хоёр үгээр одны дуран, эд ба засаг гэдгийг эдийн засаг гэсэн шинэ үг бүтээх нь элбэг байна.

Монгол хэлэнд суурилсан монгол бичгийн хэл нь одоогийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын албан ёсны хэл бөгөөд албан бичиг, сургуулийн сурах бичгээс эхлэн сонин, сэтгүүл зэрэг бүхий л зүйлд энэхүү бичгийн хэлийг хэрэглэж байна. Монгол үндэстний хэл нь цаашдаа ч монгол хэл болон монгол бичгийн хэлний төлөөлөл болж улам хөгжих болов уу.

Монгол хэлний түүх гэсэн сэдэвт нийцэх агуулгын талаар бичиж ирсэн боловч эргээд бодоход олон зүйлийг хаяж гээдүүлсэн байна. Үүнд монгол хэлний гарал үүсэл түүний түүхийн талаар нэгэн зүйл бичих ёстой байсан юм. Монгол хэлний түүхийн тухай бодож байхад монгол хэлний эзлэх байр суурь бага биш гэдэгт миний бие итгэж байна. Мөн дөрвөлжин болон, араб үсгээр тэмдэглэсэн монгол хэлний тухай ярих боломж байгаагүй нь сэтгэл дундуур байдаг зүйлийн нэг юм.

## **II. Монгол хэлний тогтолцоо**

Монгол хэлний түүхийн тухай тогтоож өгсөн энэхүү цаасны талаас илүүг дуусгаж, тогтолцооны тухай дурдах цаас бараг үлдээгүй тул 「世界言語概説下巻」(1955年、東京、


研究社), (野村正良) Номура Масаёши докторын Монгол хэлний тогтолцоо гэсэн хэсгийг лавлан үзэхийг хүсэж байна. Энд сүүлийн үеийн Altaic Theory -д чуваш түрэг хэл, монгол хэл, манж түнгүс хэл, (солонгос хэлийг оруулаад) гурав эсвэл дөрвөн хэлийг нэг овог хэл бүрдүүлдэг гэх онолыг товчхон дурдаад, тогтолцооны талаар өгүүлье.

5.2. Нэлээн дээр үед Урал Алтай хэлний овог гэдэг үг өргөн дэлгэрч, монгол хэл ч гэсэн тэрхүү овгийг бүрдүүлэгч хэлний нэгэн хэмээн үзэж байсан боловч, Урал язгуурын хэл ба Алтай язгуурын хэлний төрлийн харьцаа нь батлагдаагүй байгаа бөгөөд эдүгээ энэхүү онолыг баримтлагч эрдэмтэн тун цөөн байна.

Монгол хэл нь ерөнхийдөө алтай язгуурын хэлийг бүрдүүлэгч нэгэн хэл гэж үздэг боловч нарийвчлан үзвэл алтай хэлний овог гэдэг үгийг хэрэглэж боломгүй байгаа юм. Энэ нь дээр дурдсан гурав эсвэл дөрвөн хэлийг төрөл хэл гэж үзэх нь хэл шинжлэлийн ухаанд хараахан батлагдаагүй байгаа гэсэн үг юм. Одоогийн шатанд монгол хэл нь алтай язгуурын олон хэлийг бүрдүүлэгч хэл болж, гурав эсвэл дөрвөн хэл нь эртнээс хүчтэй харилцан холбоотой байсан биш үү гэдэг нь тохирох санал гэж бодогдож байна. Юунд асуудал байна вэ хэмээвээс энэхүү харилцаа нь гарал үүслийг нэг болгодог төрөл хэлний харилцаа юу, эсвэл үгийн сан түүнээс бусад талд харилцан зээлдмэл харилцаанаас хэтрэхгүй байна уу гэсэн зүйлд оршиж байна. Өөрөөр хэлбэл Алтай хэлний онолын (*Altaic Theory*) цөмд ч энэ асуудал байх учиртай юм.

Хэдэн жилийн өмнө хэвлэгдсэн профессор *Н.Поннегийн* “Алтай хэл шинжлэлийн удиртгал” нь эрдэм шинжилгээний хувьд анхны томоохон бүтээл болсон юм. Энэхүү номын *The Altaic Theory* гэсэн хэсэгт өмнөх олон онолуудыг түүхэн талаас нь авч үзэж, ялангуяа *G.J.Ramstedt*-ээс хойших олон онолыг *Altaic Theory*-ийг дэмжих байр суурь, дэмждэггүй байр суурь гэж хуваан, алтай хэлний онолыг дэмждэг *Н.Понне* профессор өөрийнхөө саналыг дурдан, байр сууриа тодорхой илэрхийлсэн юм. *Понне* профессорын энэхүү өгүүллээс бид алтай хэлний онолын тухай санал нэгдэх, нэгдэхгүй гэсэн хоёр хэсэгт хуваагдсан байдлыг мэдэж болох бөгөөд шулуухан хэлэхэд алтай хэлний овог гэх асуудлыг сонирхогч эрдэмтэд бүгд хүлээн зөвшөөрнө гэсэн үг биш юм.

Алтай хэлний онолыг дэмжих байр суурь нь монгол хэл судлал, алтай хэл судлалыг хослуулан судлагч нэрт эрдэмтэн *J.Ramstedt* суурийг тавьж, *B.Ya.Vladimrcov*, *J. Nemeth*, *Z.Gombocz* зэрэг эрдэмтэд залгамжлан, *проф.Понне* улам хөгжүүлсэн юм.



Алтай хэлний онолын хөгжлийг дагаад доктор *Рамстед, проф.Владимирцов* зэрэг эрдэмтний зурсан бүдүүвч (А), проф. *Понне* (В) -ээс нэлээд ялгаатай зүйл байгааг бид анхаарах нь зүйтэй юм.

Энд (А), (В)-ийн ялгаа нь нэгэн зууныг дөрөв хуваасны нэгтэй тэнцэх хугацаанд алтай хэлний судалгааны амжилтыг харуулж байна гэж бодох боловч түрэг ба манж түнгүс хэлний мэдлэг мөхөс миний хувьд (А), (В) хүснэгтийн талаар үнэлгээ өгөх эрх байхгүй тул дээрхээс өөр зүйлийг хэлэхээс зайлсхийж байна.

5.3. Дараа нь, Алтай хэлний онолыг шүүмжлэгч эрдэмтдийн байр суурийг дурдах нь зүйтэй боловч цаасны тоо хязгаартай учраас маш товчхон дурдахыг зөвшөөрнө үү. Энэхүү байр суурийг баримтлагчдыг хоёр хувааж үзэж болох бөгөөд нэгдүгээрт: алтай хэлний онол түүнийг үгүйсгэх биш, одоогийн шатанд алтай язгуурын олон хэлийг төрөл

харилцаатай хэл гэж үзэх нь цаг хугацааны хувьд эрт байна. Үүнийг нотлох баримт хангалтгүй, хүлээн зөвшөөрүүлэх чадвар дутагдалтай гэх байр суурийг баримтлагчид нь *К.Грөнбех, Ж.Р.Крюгер, Л.Лигети, Ж. Бенцинзэрэг* эрдэмтэн юм. Тэгвэл алтай хэлний онолыг үгүйсгэх байр суурь баримтлагчид нь *Д.Синьор, Г.Клоусон, Г.Дерфер* зэрэг эрдэмтдийг нэрлэж болно. Мөн *В.Котвич* нар нь алтай хэлний онолыг тууштайгаар үгүйсгэх байр суурийг баримталж байсан юм.

Дээр монгол хэлний тогтолцоог тойрсон орчин үеийн *Altaic Theory*-ийг товч танилцууллаа. Дээр дурдсанчлан монгол хэл нь алтайн олон хэлийг бүрдүүлэх хэлний нэг гэдэг нь монгол хэлний тогтолцооны талаар ярих тохиолдолд хамгийн оновчтой зүйл болов уу хэмээн бодож байна.

### **Монгол хэлний судалгаанд холбогдох ном зүй**

Монгол хэлний судалгаанд холбогдох ном зохиолыг дурдахад маш олон тоотой болох тул зарим голлох бүтээлийг ангилан товчхон тайлбарлая.

#### **1. Монгол бичгийн хэлний тухай**

(а) хэлний зүйн ном, бие даан суралцах сурах бичиг

Монгол хэлний судалгаа нь монгол бичгийн хэлний судалгаанаас эхэлсэн гэж хэлж болох бөгөөд монгол бичгийн хэлд холбогдох бүтээл нь дайны болон дайны дараагаар манай Япон улс болон хилийн чанадад ч цөөнгүй хэвлэгдсэн юм. Эхлээд манай улсад японд хэвлэгдсэн хэлний зүйн бүтээл нь:

竹内幾之助、蒙古語文語楷梯 (蒙古学 I -III 所収) 昭和 12 年~13 年、東京.

小島武男『蒙古語文典』文求堂、昭和 13 年、東京.

服部四郎、蒙古文語文法講義 (東洋語研究 I ~VI 所収) 昭和 21~23 年、東京.

Эдгээр бүтээл гарсан бөгөөд харамсалтай нь Кобаяши багшийн өөр хоёр бүтээл бүрэн дуусаагүй юм. Такэүчи, Кобаяши багшийн бүтээл нь дайны өмнөх монгол хэлний судалгааны төвшнээс харвал тэр үедээ шилдэг бүтээл болсон гэж үзэж болох болов уу. Дайны дараа удалгүй 『東洋語研究』(東京帝国大学文学部、言語学研究室会編、文求堂) сэтгүүлд гурван цувралаар хэвлэгдсэн Хаттори багшийн 「文法講義」 нь өмнөх хэлний зүйн дэвтрээс бичлэгийн арга, агуулга нь ч нэлээд ялгаатай, онцлог хэлний зүй болсон ба миний хувьд латин үсгээр бичсэн өгүүлбэрийг япон өгүүлбэрт буулган бичиж

с о н и р х о н у н ш и ж б а й л а а .

『東洋語研究』 сэтгүүл нь 4-р дугаараас хойш хэвлэгдээгүй тул 「講義」 энэхүү лекц ч тасарч, үргэлжлэн гарахыг горьдон хүлээж байгаа нь зөвхөн би ганцаараа биш байх аа.

Мөн бие даан сурах сурах бичгийн хувьд дайнаас өмнө

竹内幾乏助『蒙古語教本』螢雪書院、東京、  
精松源一、『蒙古語独習書』卷一、二、三、甲文堂、大阪、

③ сурах бичгүүд гарсан ба сүүлийнх нь монгол бичгийн хэлийг бие даан сурах үед тустай агаад түүнтэй адил төрлийн сурах бичиг байхгүй байна. Мөн

古木俊夫、蒙古語

橘瑞超、『蒙古語研究』 нэлээд дээр хэвлэгдсэн тул ахин хэвлэгдээгүй одоо огт үзэгдэхээ больсон юм.

竹内幾乏助、出村良一、『蒙古語四週間』大学書林、東京、昭和 14 年、  
хэвлэгдсэн номд монгол бичгийн хэлний тухай дурдаагүй байна.

Мөн『世界言語概説』下卷(研究社、昭和 30 年) 1955 он, номд орсон 野村正良 багшийн  
「蒙古語」болон Хаттори багшийн「蒙古とその言語」(湯川弘文社、東京、昭和 18 年)  
өгүүлэлд монгол хэлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж бичсэн байна.

#### **Гадаадад хэвлэгдсэн бүтээл:**

J. Schmidt , *Grammatik der mongolische Sprache, St-Peterburg, 1831.*

A. Бобровниковъ, *Грамматика монгольского языка, С -Петэбургъ, 1835.*

О.Ковалевский, *Краткая грамматика монгольского книжного языка, Казань, 1835.*

Б.Л. Котович, *Лекции по грамматика монгольского языка, С-Пэтэбург, 1902.*

M.G. Soulie, *Èlèments de grammaire mongole, Paris, 1903.*

А.Д. Руднев, *Лекции по грамматика монгольского письменного языка С-Петербург, 1905.*

Н.Н. Поппе, *Грамматика письменно-монгольского языка, Москва-Ленинград, 1937.*

L. Hambis, *Grammaire de la langue mongole ècrite, Paris, 1946.*

N.Popper, *Grammar of written Mongolian, Wiesbaden, 1954.*

дээрх хэлний зүйн бичгүүд нь тус тусын онцлогтой бүтээл болсон бөгөөд, Поппе профессорын дайны болон дайны дараах хоёр бүтээл нь мэдээж хэлний зүйн бичгүүдийн дотор хамгийн сайн бүтээл болсон юм.

Сүүлийн үед БНМАУ өөрийн орны хэл, бичиг соёлыг анхааран, судлах ажлыг өрнүүлж, монголч эрдэмтдийн бүтээл олноор хэвлэгдэн гарч байна. Үүний нэг Ринчен профессорын дараах бүтээл монгол бичгийн хэлний хамгийн гайхалтай хэлний зүйн бичиг болсныг хэлэх хэрэгтэй юм.

Б.Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй, I-IV, Улаанбаатар, 1964-1967.*

Энэхүү бүтээл нь 4 дэвтэр бөгөөд бүрэн дууссан эсэхийг Ринчен профессороос



асуугаагүй боловч тэргүүн дэвтэрт ерөнхий зүйл, дэд дэвтэрт авиа зүй, гутгаар дэвтэрт үг зүй, дөрөвдүгээр дэвтэрт өгүүлбэр зүйн тухай бичсэн байна. Энэхүү монгол бичгийн хэлд холбогдох хэлний зүйг орчуулах ажлаа эхэлсэн гэдгийн дурдмаар байна.

Гадаадад хэвлэсэн бие даан үзэх сурах бичгийн ихэнх нь үзэгдэхээ больсон боловч заримаас дурдъя.

Н.Н. Поппе, *Учебник монгольского языка, Ленинград, 1932.*

К. Gronbech, J.R.Krüger, *An Introduction to Classical Mongolian, Wiesbaden, 1955.*

### **(б) Толь бичиг**

Бичгийн хэлний толь бичгийг манай улсад болон гадаадад ч олонтоо хэвлэсэн байдаг.

韓穆精河、鴛淵一、精松源一、『蒙和辞典』大阪、昭和3年.

萩尾長一郎、『蒙日辞典』新京、康德10年.

ア・ペ・ヒオーニン、石田憲司、『蒙露日大辞典』東京、昭和16年.

陸軍省『蒙古語大辞典』上、中、下卷、東京、昭和8年.

дээрх 4 зүйлийн толь бичиг хэвлэгдсэн бөгөөд монгол-япон толь бичиг нь (蒙和辞典) 1944 он хүртэл 4 удаа хэвлэгдэн агуулга нь ч өөрчлөгдсөн байдаг. “Монгол- япон толь бичиг” 『蒙日辞典』 нь үгийн сангийн хувьд баялаг, шинэ үгнүүд олон орсон маш сайн толь бичиг болсон гэж хэлж болох боловч эгшиг авиа *о, и, й, ө-г* ялган тэмдэглээгүй нь харамсалтай юм. “Монгол-Орос-Япон их толь” (蒙露日大辞典) нь үгийн тоо цөөн байгаа нь дутагдалтай тал болж байна.

### **Гадаадад хэвлэгдсэн толь бичиг:**

I.J. Schmidt, *Mongolisch-deutsch-russisches Wörterbuch, St-Peterburg, 1835.*

О. Ковалевский, *Монгольско-русский-французский словарь, Казань, 1844-49.*

К.Ф.Голстунский, *Монгольско-русский словарь, С-Петербург. 1893-95.*

К.М.Черемисов, Г.Н.Румянцев, *Монгольско-русский словарь, Москва-Ленинград, 1937.*

F.D. Lessing, *Mongolian-english dictionary, Berkeley and Los Angeles, 1960.*

зэрэг толь бичгүүд хэвлэгдсэн байх агаад хятадад ч хэд хэдэн монгол-хятад толь бичиг гарсан байна.

Лессинг профессорын толь нь орчуулсан үгийн оноолт сайн, маш хэрэгтэй сайн толь бичиг болсон ба үгийн тоо нь Ковалевский, Голстунскийн тольтой харьцуулахад цөөн байгаа шиг санагдсан. Ковалевский, Голстунскийн толийг монгол бичгийн хэлний толь хэмээн үнэлэгдсэн боловч авианы тэмдэглэгээний хувьд дутагдал байхгүй гэвэл тийм биш юм. Гэвч одоогоос зуу гаруй жилийн өмнө хэвлэгдсэн гээд бодоод үзвэл түүний агуулга нь эргэлзэх зүйлгүй алдаа мадаг байхгүй байгаад гайхшрал төрүүлж байна.

## Орчин цагийн монгол хэл болон бичгийн хэл

Орчин цагийн халх монгол хэлийг орчин цагийн монгол хэл гэж нэрлэн, халх монгол хэлийг суурь болгон кирилл үсгээр тэмдэглэсэн бичгийн хэлийг орчин цагийн монгол бичгийн хэл гэж нэрлэе хэмээн өгүүллийнхээ эхэнд дурдсан бөгөөд холбогдох ном зохиол цөөн байдаг. Доор зарим төлөөлөх бүтээлийг дурдья.

### а. Хэлний зүйн бичиг, бие даан суралцах сурах бичиг

G.J. Ramstedt, *Über die Konjugation des Khalkha-Mongolischen*, MSFOu XXI, 1902.

服部四郎、蒙古の口語と文語、『蒙古学報』第2巻、東京、昭和16年(1941).

G.J. Ramstedt, *Das Schriftmongolische und die Urgamundart phonetisch verglichen*, JSFOu XXI, 2, 1903.

Б.Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка халхаского наречия*, Ленинград, 1929.

N.Poppe, *Khalkha-Mongolische Grammatik*, Wiesbaden, 1951.

Б.Х. Тодаева, *Грамматика современного монгольского языка*, Москва, 1951.

А.Р. Ринчинэ, *Учебник монгольского языка*, Москва, 1952.

Г.Д. Санжеев, *Современный монгольский язык*, Москва, 1959.

W.M. Austin, J.G. Hangin, P.M. Onon, *Mongol Reader*, The Hague, 1963.

J.C. Street, *Khalkha Structure*, The Hague, 1963.

小沢重男、『モンゴル語四週間』東京、昭和38年(1963)

Т.А. Бертагаев, *Синтаксис современного монгольского языка*, Москва, 1964.

J.E. Bosson, *Modern Mongolian*, The Hague, 1964.

J.G. Hangin, *Basic Course in Mongolian*, The Hague, 1968.

小沢重男、『モンゴル語の話』東京、昭和43年(1968)

H.P. Fietze, *Lehrbuch der Mongolischen Sprache*, Leipzig, 1969.

дээрхээс өөр бичигдээгүй бүтээл байж болох авч тийм ч олон биш болов уу гэж бодож байна.

Рамстедт докторын 2 бүтээл, Владимирцов профессорын бүтээл нь сонгодог, шилдэг, халх монгол хэлний судалгаанд орон зайгаа эзэлсэн бүтээл болсон. Поппе профессорын “Халх монгол хэлний хэлний зүй” нь хэлний зүйг нэгтгэн бичсэн цорын ганц бүтээл болох бөгөөд, мөн Тодаев-гийн “Орчин цагийн монгол хэлний хэлний зүй” -гээс өөр өнөөг хүртэл ийм төрлийн бүтээл хэвлэгдээгүй байна. Боссон нөхрийн *Modern mongolian*, Хангин нөхрийн *Basic course* нь монгол хэл, монгол бичгийн хэлийг бие даан сурахад нийцсэн бүтээл юм. Миний 2 бүтээл нь монгол бичгийн хэлийг тайлбарлан

бичсэн бүтээл болох агаад манай улсад ийм төрлийн бүтээл хараахан гараагүй байна.

### **6. Толь бичиг**

Халх монгол хэлний толь бичиг нь бичгийн хэлний толь бичигтэй харьцуулахад цөөн, доорх хэдэн толь бичгийг дурдаж болно.

А.Р. Ринчинэ, *Краткий монгольско-русский словарь*, Москва, 1947.

А.Лувсандэндэв, *Монгольско-русский словарь*, Москва, 1957.

Ш.Цэвэк, *Mongoliach-Deutsches Wörterbuch*, Leipzig, 1961.

Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966.

精松源一、『新蒙日辞典』大阪、昭和30年(1955)

А.Лувсандэндэвийн “Монгол-Орос толь “ нь сайн толь боловч үгийн тоо цөөн, Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь ” нь одоогийн байдлаар хамгийн олон үгтэй толь бичиг бөгөөд монгол хэл судлаачийн хувьд ширээний ном болсон юм. Манай улсад Абэмацү багш арав гаруй жилийн өмнө “Шинэ монгол-япон толь бичиг” -ийг хэвлүүлсэн нь монгол хэл, монгол бичгийн хэлний судалгаанд тус нэмэр үзүүлсэн юм. Мөн Цэвэгийн толь нь жижиг, үг цөөтэй боловч агуулгын хувьд муу биш юм.

### **3. Орчин цагийн монгол хэл аялгуу**

Монгол хэл аялгууны тухай онцлох бүтээлийг дурдья.

1. Н.Н. Поппе, *Бурят-монгольское языкознание*, Ленинград, 1933.

2. Н.Н. Поппе, *Грамматика бурят-монгольского языка*, Москва, 1938, Ленинград

3. Г.Д. Санжеев, *Грамматика бурят-монгольского языка*, Москва, 1941.

4. 服部四郎、ブリヤート方言の分類『蒙古学報』第一号) 東京、昭和15年(1940)

5. К.М. Черемисов, *Бурят-монгольско-русский словарь*, Москва, 1951.

6. А. Попов, *Грамматика кальмыцкого языка*, Казань, 1847.

7. Г.Д. Санжеев, *Грамматика кальмыцкого языка*, Москва-Ленинград, 1940.

8. А. Позднеев, *Кальмыцко-русский словарь*, С-Петербург, 1911.

9. G.J. Ramstedt, *Kalmückisches Wörterbuch*, Helsinki, 1935.

10. У.У. Очиров, *Грамматика кальмыцкого языка*, Элиста, 1964.

11. A. Mostaert, *Le dialecte des Mongols Urds*, Anthropos XXII, 1927.

12. A. Mostaert, *Ordossica. Bulletin of the Catholic University*, Peking 1934.

13. A. Mostaert, *Textes oraux ordos*, Peking, 1937.

14. A. Mostaert, *Dictionnaire ordos*, Peking, 1941-44.

дээрх 1-5 нь буриад аялгууны хэрэглэгдэхүүн, 6-10 нь халимаг аялгууны хэлний зүй, толь бичиг, 11-14 нь Өвөр монголын ордос аялгууны хэрэглэгдэхүүнүүд юм. Үүнээс

бусад аялгууны хэрэглэгдэхүүний заримаас дурдьяа.

1. A. Smedt, A. Mostaert, *Le dialecte Monguor parlè par les mongols du Kansu Occidental*. Anthropos XXIV, 1929; XXV, 1933.
2. A. Smedt, A. Mostaert, *Le dialecte Monguor parlè par les mongols du Kansu Occidental, Iie Partie, Grammaire*, Peking, 1945.
3. A. Smedt, A. Mostaert, *Dictionnaire monguor-français*, Pei-ping, 1933.
4. G.J. Ramstedt, *Mogholica. JSFOu* XXIII, 4.
5. S. Iwamura, *The Zirni Manuscript*, Kioto, 1961.
6. Н.Н. Поппе. *Дагурское наречие*, Ленинград 1930.
7. S.E. Martin, *Dagur Mongolian*, The Hague, 1961.
8. Б.Х. Тодаева, *Баонский язык*, Москва, 1964.
9. Б.Х. Тодаева, *Дунсянский язык*, Москва, 1961.
10. Б.Х. Тодаева, *Язык желтых уйгуров*, Москва, 1966.

үүний дотроос 1-3 нь монгол аялгууны (Хятадын Ганьсү муж) тухай, 4-5 нь Афганистаны могол аялгууны хэрэглэгдэхүүн юм. 6-7 нь манж монголын дагуур аялгууны хэрэглэгдэхүүн бөгөөд 8-10 нь Хятадын хил орчмын бүс нутагт хадгалагдан үлдсэн онцлог аялгууны бүтээлүүд юм. Дээрх монгол аялгуу нь үүнд орсон байна. Эдгээр аялгууг бусад монгол хэл аялгуутай харьцуулахад олон хэлбэрт өөрчлөлт гарсан нь харагдаж байна. Судалгааны хэрэглэгдэхүүн болохын хувьд үнэхээр сонирхолтой аялгуунууд гэж хэлж болно. Могол аялгуунаас бусад нь хятадын нутаг дэвсгэрт байдаг тул одоогийн олон улсын байдлаас болж тухайн газарт судалгаа явуулах боломжгүй байгаа нь харамсалтай байна.

Эцэст нь дундад үеийн монгол хэлний судалгааны хэрэглэгдэхүүнийг дурдах нь зүйтэй гэж бодсон боловч төлөвлөсөн цаасны тоо нэгэнт дууссан тул өөр нэгэн боломж олдвол дурдьяа. Энд зөвхөн хэвлэгдсэн бүтээлийг танилцуулсан бөгөөд эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллийг орхихоос аргагүй болсныг тэмдэглэхийн ташрамд дээр дурдсан Поппе профессорын Халх монгол хэлний зүй номны эцэст 1951 он хүртэлх монгол хэлний судалгаанд холбогдох нарийн ном зүйг хавсаргасныг дурдахыг хүсэж байна.

Тус өгүүллийг өнгөрсөн оны (1968) японы их сургуулиудад гарсан оюутны хөдөлгөөн, өөрөөр хэлбэл хэвийн бус орчинд энэхүү өгүүллээ бичсэн тул хангалтгүй санагдсан зүйлүүд байгааг одоо ажиглаж байна. Биеийн болон сэтгэл санааны хүнд нөхцлийн дунд их сургуулийн оюутны хөдөлгөөнийг санагалзан ямар нэгэн засвар хийлгүйгээр энэ хэвээр нь хэвлүүллээ.